

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл  
2009/1 (27)  
Улсын бүртгэлийн дугаар 244  
Жил 4 удаа хэвлэгдэнэ.  
8 дахь жилдээ

#### **Сэтгүүлийн редакцийн зөвлөл**

Д.Солонго Ерөнхий редактор /ХЭҮК-ын дарга/  
Ц.Адъяахишиг Нарийн бичгийн дарга /ХЭҮК-ын ахлах референт/

#### **Гишүүд:**

Ж.Амарсанаа /ШУ-ны академийн жинхэнэ гишүүн Академич,  
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн/  
С.Нарангэрэл /ШУ-ны академийн жинхэнэ гишүүн Академич,  
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, МУИС-ын ХЗС-ийн захирал/  
Л.Баасан /Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, ОТИС-ийн дэд захирал/  
Н.Мөнхбат /НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Хүний  
эрхийн шинжээч/  
Л.Мөнхцэцэг /ХЗДХЯ-ны ХЭХҮХ-ийн Ажлын албаны дарга/  
Р.Оюунцэцэг /Хэвлэлийн хүрээлэнгийн сэтгүүл зүйн багш,  
докторант/

## АГУУЛГА

Д.Энхжаргал Шашин шүтэх эрх чөлөө	3
Ш.Үнэнтөгс Хуулийн амин сүнс	11
Б.Батцэцэг Хүүхэд үрчлэлтийн талаарх эрх зүйн орчин, нөхцөл байдал	18
Г.Оч Бизнес ба Хүний эрх	29
Э.Энхжаргал Захиргааны хэрэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрх	37
Б.Болорсайхан Эрхэд суурилсан хандлага	48
<b>Таны танин мэдэхүйд</b>	
Хүний эрхийн олон улсын нэр томъёо	69
Таны хүний эрхийн мэдлэг шалгах сорил	75
Хүүхдийн эрхийн тухай конвенци /Хүүхдэд зориулсан хялбаршуулсан хувилбар/	83
Үгийн сүлжээ	91

**ШАШИН ШҮТЭХ ЭРХ ЧӨЛӨӨ**

*Шашны боловсрол эзэмших боломжийг эрэхүй*



**Д.Энхжаргал**

ХҮДС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны  
тэнхимийн багш, докторант

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Хүний эрхийн түгээмэл Тунхаглал”-ыг баталсан билээ. Уг тунхаглалын 18-р зүйлд: “Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шүтэж бишрэх, сүсэглэх эрхтэй, энэ нь шашин шүтлэг буюу үзэл бодлоо өөрчлөх эрх, ганцаараа буюу бусадтай хамтран нийтийн болон хувийн журмаар шашин шүтлэг, үзэл бодлоо заан түгээх, мөргөл хийх, сургаал гүйцэтгэх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх эрхийг хамарна”<sup>1</sup> гэж шашин шүтэх ба итгэл бишрэлтэй байх эрх чөлөөг онцолсон байдаг. Энэхүү заалтын үзэл санаа дэлхийн олон улс орны хуулинд тусгагдан орж, олон улсын хэмжээнд шашны эрх чөлөө нь хүний суурь эрхийн нэг болсоор ирсэн билээ.

Монгол улс нь НҮБ-д элссэнээс хойш хүний эрхийн салбар дахь үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, олон улсын хэмжээнд батлан гаргасан гэрээ конвенциудад нэгдэн орж, хүний эрхийг баталгаажуулах үйл хэрэгт дэвшилтэт улс орнуудтай мөр зэрэгцэн явж ирсэн юм. Ардчилсан Монгол улсад бодит биелэлээ олсон хүний эрхийн нэг нь шашин шүтэх, эс шүтэх эрх гэж хэлж болно. Монгол Улсын үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16-р зүйлийн

<sup>1</sup> Хүний эрх. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл.НҮБ.УБ.,1992.18-р зүйл

15-д Монгол улсын иргэн нь “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй”<sup>2</sup> хэмээн хуульчлан баталгаажуулсан байдаг. Тийнхүү шүтэн бишрэх эрх чөлөөг хуульчлан баталгаажуулж, жинхэнэ утгаараа хэрэгжих боломжийг нээж өгснөөр манай орны иргэдийн шүтлэг бишрэл ил, чөлөөтэй болсны дээр бусад шашны урсгалуудыг шүтэх, дэлгэрүүлэх боломжтой болсон юм.

Шашин шүтлэгийн талаар хийгдсэн сүүлийн жилүүдийн судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын 90 гаруй хувь нь өөрийгөө ямар нэг хэмжээгээр сүсэг бишрэлтэй гэж тодорхойлдог байна. Тухайлбал, 1994 онд явуулсан судалгаагаар оролцогчдын 71.1 хувь нь шүтлэгтэй<sup>3</sup> гэсэн байхад 2006 онд судлаач Б.Оюун-Эрдэнийн хийсэн судалгаагаар 61.4 % нь Бурхны шашин, 30.6% нь Христ, 6.1% нь Ислам, 1.9% нь бусад шашныг шүтдэг<sup>4</sup> гэж хариулсан байна. Социологийн судалгаануудын дүн болон өнөөгийн нийгмийн бодит байдлаас үзэхэд хүн амын шашин шүтлэг плюральчлагдаж, шашныг сонирхогч, шүтэн бишрэгч, талархан дэмжигчдийн тоо өсөж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хүрээ тэлсэн нь харагддаг. Монгол Улсад 2005 онд 33 шашны байгууллага үйл ажиллагаа явуулж байсан бол 2008 оны 5-р сарын байдлаар Будда-226, Христ-153, Бөө-6, Ислам-27, Бахай-3, Мүни-1 сүм хийд Хууль зүй Дотоод хэргийн Яаманд албан ёсоор бүртгүүлж үйл ажиллагаа явуулж байв<sup>5</sup>.

Ийнхүү шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө бодит биелэлээ олсон өнөөгийн энэ үед сүсэгтнүүд өөрсдийн шүтэн бишрэх эрхийнхээ


<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хууль.УБ., 1992.16-р зүйл.

<sup>3</sup> Цэдэндамба.С Монгол дахь шашин, сүсэг бишрэлийн хэтийн төлөв, хандлага. Диссертаци. УБ.,1999. т.3

<sup>4</sup> Оюун-Эрдэнэ.Б Монголын бурхны шашны өнөөгийн нөхцөл байдал, түүнийг шинэчлэх асуудал. Диссертаци. УБ.,2007. т.57

<sup>5</sup> Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээ. 2008 оны 5 сар


дагуу шашны талаарх мэдээлэл, мэдлэгээ хэрхэн олж авдаг, үнэн зөв, бодит мэдлэгтэй байж чаддаг эсэх асуудал анхаарал татаж байна. Бид үүнийг бурхны шашин шүтэгчдийн жишээн дээр судлан тодруулах үүднээс 2008 оны 3-р сард социологийн бичил судалгаа хийсэн юм. Энэхүү судалгааны үр дүнд дараах дүр зураг тодорч байна. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо бурхны шашин шүтдэг гэж өөрсдийгөө тодорхойлсон дунд болон дээд боловсролтой 150 иргэдийг хамруулсан юм. Судалгааныхаа хүрээнд бурхны шашинтнуудын хувьд орчин үеийн хэллэг ойлголтоор бичигдсэн тулгуур бүтээл болох “Бурхан багшийн сургаал” номыг уншсан уу?” гэсэн асуултанд доорх байдлаар хариулсан нь нэгийг өгүүлнэ.



Мөн “Та шашны тухай мэдээллээ хаанаас олж авдаг вэ” гэсэн асуултанд 56.1% нь ойр дотны настан буурлуудаас мэдэж авдаг гэсэн бол “Бурхны шашны талаарх хэвлэгдэн гарч буй ном зохиолууд нь хэр ойлгомжтой байдаг” талаар 70 орчим % нь нилээд хүнд хэл найруулгатай, ойлгоход хэцүү гэж хариулсан байна.

Судалгааны дүнгээс харахад нийт оролцогч бурхны шашинтнуудын 31% нь “Бурхан багшийн сургаал” номыг уншсан байгаа нь тун чамлахаар үзүүлэлт бөгөөд харьцангуй өндөр боловсролтой иргэдийн хүрээнд ийм ядмаг үзүүлэлт гарч байгаагаас дам ургуулан үзвэл боловсрол багатай иргэдийн энэ талын мэдлэг ямар хэмжээнд байгаа нь ойлгомжтой мэт. Дээрх үзүүлэлтүүд нь бурхны шашин шүтэгчид шашныхаа талаар төдийлөн бодитой ойлголтгүй, энэ талаарх мэдээлэл төдийлөн наалдацгүй, хэвлэгдэн гарч буй ном материал нь ойлгоход хүнд хэллэгээр бичигддэг, ойр дотны настангуудын дууриал, заасан дадал заншлаар баримжаалан маань, мэгзэм уншиж, Ганданд мөргөл үйлдсэнээр шашин шүтдэг гэсэн ойлголт нь хязгаарлагддаг тал харагдаж байна. Нөгөө талаар үүнийг иргэдийн шүтэн бишрэх эрхийнхээ дагуу үнэн зөв мэдлэг, мэдээлэлээ олж хүртэх нөхцөл боломж төдийлөн хангалтай бус байна гэж дүгнэж болно.

“Шашны мэдлэг боловсролтой үзэж байна вэ?” асуултанд дараа



Үүнээс харвал ёс суртахууны хүмүүжил, танин мэдэхүйн ач холбогдлыг эн тэргүүнд тавих болсны дээр шүтлэг бишрэлийн

зорилго, түүнд хандах хандлагад чанарын өөрчлөлт гарч байгаа нь илт байна. үүнийг бид шашны мэдээлэл, мэдлэг олгох үйл ажиллагаандаа анхаарах хэрэгтэй бөгөөд шашны зөв, бодитой мэдлэг боловсрол олгох, шаардлага хангахуйц чанартай сургалт, хүнд хүрэхүйц үр өгөөжтэй мэдээлэл сурталчилгаа чухал шаардлагатай бөгөөд үүнийг тухайн шашныг сурталчлах утгаар биш, иргэдэд шүтэн бишрэх эрхээ эдлэх боломж олгож буй талаас нь авч үзэх, ойлгох нь хэрэгтэй юм.

Өнөө үед хүмүүс шашин шүтлэгийг эрхэмлэн үзэж, амьдрал ахуйдаа баримтлан явахыг эрмэлзэх болсныг ч судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, “Шашин шүтлэг таны амьдралд хэр нөлөөтэй вэ? гэсэн асуултад 61.8% нь их нөлөөтэй гэж үзсэн ба “Та шашны мэдлэгийг зориуд олгох шаардлагатай гэж үздэг үү?” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 62.2% нь дэмжсэн хариултыг өгсөн явдал үүнийг нотолж байна.

Бидний явуулсан тандалт судалгаанаас үзэхэд, манайд уламжлалт шашны мэдлэг ухааны сургалт сурталчилгаа учир дутагдалтай, лам нарын мэдлэг чадвар зарим талаар хүмүүсийн санаанд төдийлөн нийцдэггүй бөгөөд энэ нь сүсэгтнүүдийг хэрэгцээгээ хангах өөр арга зам, шашныг эрэлхийлэхэд хүргэдэг болох нь харагдсан билээ. үүнийг урьд өмнө явуулсан судалгаа ч давхар нотолж байна. Тухайлбал, 2006 оны 11 сард судлаач Д.Оюун-Эрдэнийн 500 орчим хүн хамруулан хийсэн судалгаанаас үүнийг харж болох ба “Лам нарын мэдлэг, чадвар, ёс зүйн боловсролын асуудлыг юу гэж үзэж байна? гэсэн асуултанд оролцогчдын 40.8% нь хангалтгүй гэж хариулсан ажээ”<sup>6</sup>.

<sup>6</sup> “Бурханы шашин болон Христийн шүтэгчдээс авсан судалгаа”. Д.Оюун-Эрдэнийн 2006 оны 11 сард хийсэн судалгаанаас

Мөн бид энд доктор С.Цэдэндамбын “өнөөгийн жирийн шүтлэгтэй иргэдийн боловсролын түвшин сүм хийдийн лам нараас дутахааргүй илүү болох хандлагатай байна. Энэ нь өмнөхөөс өөр маягийн сүсэгтэн төлөвшиж буйг гэрчилж байна”<sup>7</sup> гэсэн судалгааны дүгнэлтийг хайхрахгүй өнгөрч болохгүй юм.

Судалгаанаас үзэхэд шашин шүтэгчдийн боловсролын түвшинг харвал дээд боловсролтой шашин шүтэгчдийн эзлэх хувь (35.3%) буюу нилээд хэсгийг эзэлж байгаа нь мэдлэг боловсрол нимгэнтэй нь шашинд илүү автагддаг гэх атеист үзэл суртлын ойлголт өнөөгийн шүтлэг бишрэлийн шинж чанартай яавч дүйцэхгүй нь илт байна. өөрөөр хэлбэл, шашин шүтэгчдийн боловсролын түвшин дээшилж байгаагаас шалтгаалж, хүмүүс өнгөц төдий зан үйлээс илүү дотоод мөн чанар руу нь өнгийн харахыг хүсдэг болсон тал ажиглагдаж буй юм.

Эндээс бурхны шашны лам нарыг бэлтгэдэг, шат ахиулдаг сургалтыг чанаржуулах талаар сүм хийдүүд анхаарахгүй бол сүсэгтнүүдийнхээ оюуны хэрэгцээг хангаж чадахгүйд хүрч, улмаар энэ байдал нь шашны нь нэр хүнд унах, улмаар өв соёл, ёс уламжлалаа үл хүндлэх байдал, хандлага даамжрахад хүргэж болох талтайг анхаарах хэрэгтэйг харуулж байна. Сүсэгтнүүдийнх нь бурхны шашны талын өнгөц мэдлэг, хомс ойлголт нь илүү сайн мэдээлэл сурталчилгаатай бусад шашныг сонирхон дагаж хошуурахад хүргэж буйг ч үгүйсгэх аргагүй юм.

Шашны үнэн зөв мэдлэг нь хүн төрөлхтний соёл, мэдлэг ухааны өв уламжлалыг хүүхэд залуус, олон нийтэд эзэмшүүлэх, ёс

<sup>7</sup> С.Цэдэндамба. Монгол дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе). УБ.,2003. тал 93



суртахууны хүмүүжил, хүмүүнлэг үзлийг төлөвшүүлэхэд чиглэгддэг бөгөөд шашны зөв зохистой мэдлэг олгох нь олон түмнийг мунхруулан шашинжуулж, шашны суртал нэвтрүүлэг хийх хэмээсэн хэрэг бус харин тэрхүү шашнаас өнөөдрийн нийгмийн харилцаан дахь сэтгэл зовоосон олон асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр болгох, хүнлэг энэрэнгүй үзэл, ёс суртахууны эрхэм чанарууд, эвч нийтэч үзэл, бусдыг хүлээн зөвшөөрөх, хайрлах, нигүүлсэх, ухаарч гэгээрэх чанар, чадвар зэрэг үнэ цэнэтэй нандин өвийг өнөөшүүлэн өвлүүлэх гэсэн хэрэг юм.

Аливаа сүсэгтэн өөрийн шашин, өв соёлоо ойлгож мэдэхийн хирээр хүнлэг чанаруудыг эзэмшиж, бусдын шашин, соёл, уламжлалд хүндэтгэлтэй хандах, аль ч соёл иргэншлийн төлөөлөлтэй нийцэн орших, нийгмийн бүх талын харилцаанд оролцохдоо эерэг нөлөө үзүүлэх чадвартай болдог. Дэвшүүлэн буй асуудлыг хүлээн авах, түүнийг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө бид шашны тухай хуучирсан явцуу ойлголт сэтгэлгээ, үзэл хандлагаасаа татгалзаж, түүний мөн чанарыг шинээр нээн харахыг эрмэлзэх ёстой болж байна.

Тиймээс өнөөдөр Монголд бий болоод байгаа нөхцөл байдал, хүмүүжил, ёс суртахууны доройтлыг гэтлэн давах нэг арга зам бол шашны зохих хэмжээний боловсрол олгох, үүгээр дамжуулан ёс суртахууны эрхэм чанаруудыг эзэмшүүлэх, хүн арддаа хүмүүнлэг, энэрэнгүй үзлийг төлөвшүүлэх явдал гэж үзэж байна.

Тэрчлэн энэ нь хүн амд шашин шүтэх эрх чөлөөгөө бодитой хэрэгжүүлэх боломжийг нээж өгч, иргэдэд шүтдэг шашныхаа тухай мэдээлэл, мэдлэг олж авах, суралцах, түүнд төр, шашин сүм хийд, нийгмийн зүгээс оролцох, туслан тэтгэсэн бодлого хэрэгжүүлэх шаардлага чухлаар тавигдаж байгааг илтгэж байна.

Өнөөдөр хүн амын дийлэнх нь буддын шашин шүтдэг манай орны хувьд юуны өмнө буддын шашны сургаал, мэдлэг ухаанд түшиглэн хүн амд шашны сургалт, боловсрол олгох ажлыг сонирхолтой, үр дүнтэй, оновчтой зохион байгуулж хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг боловсруулан ажил хэрэг болгож эхлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улсын “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль”-д заасанчлан: “Төрийн харъяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулах” нь хориотой боловч сүм хийд, олон нийт, төрийн бус байгууллагуудын зүгээс эн тэргүүнд албан бус сургалтын арга хэлбэрийг ашиглан энэхүү боловсролыг олгох боломж нээлттэй байгааг ашиглах нь зүйтэй байна. Бүх нийтийн шашны боловсролд гол үүрэг гүйцэтгэх чухал төв, үндсэн бааз газар нь сүм хийдүүд мөн болох тул тэдний зүгээс дагнасан болон бусад зорилго нэгт байгууллага, хүмүүстэй нягт хамтарсан идэвхтэй үйл ажиллагаа явуулж, энэ үйл хэргийг хэрэгжүүлэхэд шинэ менежментээр санаачлагатай ажиллаж сүсэгтнүүдээ бодит мэдээллээр хангаж, шүтэх эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй юм.

**“ХУУЛИЙН АМИН СҮНС”**



**Ш.Үнэнтөгс (LLM)**

**“Хуулийн амин сүнс” буюу бид хөгжмөөр л байна...**

**Гэхдээ саад байна.**

Хууль болгон амин сүнстэй байх ёстой гэдэг. Сүнсгүй хүн амьдрахгүйтэй адил, амин сүнсгүй хууль оршин тогтнохгүй. Гэтэл манай улсад хүчин төгөлдөр үйлчилж буй гэх 432 хуулийн хичнээн нь сүнсгүй, хий үзэгдлийн шинжтэйгээр тэнүүчилж буйг тааварлахад нэн бэрх биш. Та бод л доо, манай монголчууд уулаасаа л хагас зэрлэгшингүү, нүүдлийн байдалтай, баригдамхай бус болохоороо тэгдэг юм уу аливаад урьд шийдэгдсэн жишигийг хэрэгсэхгүй, асуудал бүрт тохирсон шинээр хууль гарган шийдвэрлэдэг байх, зөвхөн өөрт нь, тухайн субъектэд ашигтай, зориулагдсан байхаар шийддэг. Нөгөөтэйгүүр хойчийн үед зөвхөн өөрт тааламжтайгаар асуудлаа шийдэх боломжоо бэлдэх үүднээс хууль санаачлагчид болоод тогтоогчид хуулиа засамжилдаг. Энэ нь товчхондоо манай монголчууд хагас зэрлэг, тухайн асуудал шийдэгдэхгүй бол заавал өөрийн хүсснээр, өөртөө нийцүүлэх боломжтой газраа нүүдэллэн хүчээр шийддэг, эрх зүйн соёл төлөвшиж, нэвтрээгүй бүдүүлэг харанхуй байгаа гэдгийг илтгэдэг.

Монгол төрт ёсны түүхэн уламжлал нэн эртнээс хэтийдсэн үндэстэн гэдэг ч үнэндээ арван зургаадугаар зуунаас хойш алдагдан, өргөн хүрээтэй бус жалгын сэтгэлгээ ноёрхсон байдлаас үүдэлтэйгээр өдгөө эрх зүйн төлөвшилтийн зохистой байдал алдагдаад байгаа нь нөлөөлж, тэр эрт үеээс эхлэн монголын хууль

гурван хоног гэх сэтгэлгээний төлөвшил тогтчихсон. Учир нь монголын феодалууд хэлэлцэн, уралцан байж нэг хууль, эрхийн акт гаргачихаад түүнийгээ нөгөө баталсан субъект нь өөрөө эхлэн зөрчснөөр үнэ цэнэгүй болгочихдогийг хэлсэн үг биз. Тэгвэл одоо манай үед энэ нь яг хэвэндээ, бүр дордсон байдалтай байна. Тухайлбал, социализмыг цогцлоох үед төрийн шийдвэр, намын даалгавар хоёрын аль нь хүчин чадалтай эрх зүйн баримт болохыг ялгалгүй явж ирсэн, одоо ч гэсэн олон хууль, эрхийн актуудын давхардал, хийдэл, үйлчлэл яах эсэх нь арга зүйн технологийн хувьд шийдвэрлэгдээгүй, урсгалаараа л байна.

Ингэхээр хуулийн үйлчлэлийг уртасгах, алсын хараатайгаар асуудлыг хэт нарийвчилсан бусаар эрх зүйн хувьд зохицуулдаг, үзэл санаа, үзэл баримтлалыг явцуурсан бусаар ойлгож, агуулгын хүрээнд боломжит бүхий л хувилбараар ашигладаг байх, түүнийг заавал хэрэгжүүлдэг механизм, гол нь сэтгэлгээний хуваарийг бүрдүүлэх нь туйлаас чухал.

Үүнийг л хуулийн амин сүнс гэмүй. Тэгж л би ойлгодог.

Одоо манай хуулийнхан /lawmakers/ яаж байна гээч. Хуулийг амин сүнстэй, удаан хугацаанд үйлчлүүлдэг болгож байна гээд урьд нь хүнд, тухайн байгууллагад нь зориулсан байдаг хууль, түүний зүйл, заалтыг нь тухайн ийм, тийм асуудал эрхэлсэн тийм байгууллага гэх мэт хэт явцуурсан, жижигэрсэн өрөөсгөл байдлаар л шийддэг болчиж гэж хатуухан хэлэхэд болох байх аа.

Ганцхан жишээ хэлэхэд үндсэн хууль, түүний органикийн нэг үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн **“амин сүнсийг” /spirit of law/** үндсэн хуулийн цэцийн дарга Г.Совд багш **“Цэцийн дээр хөх тэнгэр л бий”** гэж алдарт үгээрээ томъёолсон байдаг. Энэ л тухайн хуулийн амин сүнс, концепцийг илэрхийлэн түүнд үйлчлэл,

агуулга нь нийцэх учиртай билээ. Түүнээс биш одоо үйлчилж байгаа Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн дагуу батлагддаг хуулийн төслийн үзэл баримтлалд бичигдсэн зүйлийг хэлдэггүй. Тэгэх боломж ч байхгүй. Бусад эрхзүйн өндөр төлөвшилтэй улсуудад ч ийн хэрэглэгдэн, хэлцэгддэг.

Гэтэл манай улсад маш зөвөөр тодорхойлогдон томъёологдсон дээрх хуулийн амин сүнсийг андуураагүй бол одоогийн үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж гуай бил үү, хэн нэг нөлөөтэй эрхэм **“Цэцийн гишүүдийн дээр малгай бий”** гэж Г.Совд багшийн хэлсэнд хариу барьж, удалгүй хуулийн өөрчлөлт, томилолтоороо түүнийгээ баталгаажуулан амин сүнсийг нь үлдэн хөөсөн юмдаг. Энэ жишээ л миний дээр хэлсэнчлэн монголчууд хагас зэрлэгшингүү, эрх зүйн соёл, төлөвшилгүй, хуулийн үйлчлэл гурван хоног байдагт нөлөөлж буйг нотлож байна.

#### **“Хүний амь өднөөс хөнгөн” гэх тухайд**

Бусад эрх зүйн өндөр төлөвшилтэй улс оронд хуулийн амин сүнсийн тухай ойлголтыг янз бүрээр тайлбарлан, магадлал дэвшүүлдэг ч үндсэндээ тухайн эрх зүйн бүлээс үл хамааран хуулийн тогтвортой, чадварлаг зохицуулалтын хүрээ хязгаараар шалгуур тогтоон түүнийгээ дэмжих, бэхжүүлэх стратегийг харьцангуй тогтвортойгоор баримтладаг.

Тухайлбал, Японы Боловсролын хуулийн амин сүнсийн тухай гэхэд 1890 онд Японы эзэн хааны **“Кёоикүчёкүго”** гэх япон хүний баримтлах ёстой ёс суртахууны хэм хэмжээг заасан боловсролын тухай айлдвар гарсан байдаг. Үүний гол концепци нь эзэн хаан, ард түмэн хоёр салшгүй зүйл гээд, хүн бүрийн сурах, баримтлах ёс суртахууны хэм хэмжээг зааж, шаардлага гарсан үед эх орныхоо

төлөө амиа хайрлахгүй байхыг уриалсан. Дэлхийн хоёрдугаар дайны дараа дайнд ялсан АНУ Японыг засамжлахын тулд эрдэмтэдээ ирүүлж судалгаа хийлгэсэн байдаг. Тэд японыг түргэн хугацаанд хүчирхэгжүүлж, милитарист дайнч гүрэн үүсгэсэн гол хүчин зүйл нь Эзэн хааных нь тэр айлдал байж гэж дүгнэн өөрчлөх зорилт тавьсан гэдэг. Ийнхүү япончууд **“хүний амь өднөөс хөнгөн”** гэж зааж байснаа **“хүний амь дэлхийгээс хүнд”** гэж ярьж эхэлснээр японы боловсролд эрс өөрчлөлт орсон гэдэг. Нөгөөтэйгүүр Япон улс шинэ Үндсэн хуулийнхаа үзэл санаанд тулгуурлан 1947 онд Боловсролын хуулиа гаргасан юм. Тухайн хуулийн амин сүнс нь **“Боловсролын үйл ажиллагааны үндсэн зорилго бол хүний бүрэн төлөвшилд оршино”** гэж заасан нь бөгөөд энэ нь тухайн орныг эдийн засаг технологийн их гүрэн болгоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Тэгээд ч сайтар зохицуулсан харилцаагаа удаан хугацаанд тогтвортой мөрдсөн бөгөөд 1947 онд баталсан боловсролын хуулиндаа *59 жилийн дараа* буюу 2006 онд уламжлалт соёл, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулсан гэдэг. Энэ бол хуулийн амин сүнс бодитоор оршсоноос тухайн улс үндэстэнд үр нөлөөгөө өгөх, эрх зүйн төлөвшил, хууль дээдлэх ёс суртахуун хэр ач тустай болдгийн нотолгоо юм.

Гэтэл Монголд Боловсролын хуулийн тухайд гэхэд 90-ээд оноос өмнө үйлчилж байсан хуулиа хүчингүйд тооцож, 1991 оны 6 дугаар сарын 21-нд БНМАУ-ын Бага Хурлаас БНМАУ-ын Боловсролын хуулийг шинэчлэн баталсан байдаг. Мөн УИХ-аас 1995 оны 6 сард Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай буюу Боловсролын багц хуулийг баталсан бөгөөд тэр хуулинд 1998 оны 7 сард, 2000 оны 2 сард тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна. Харин долоон жилийн дараа 2002 онд Боловсролын багц хууль дахин шинэчлэгдэн батлагдсан байх

бөгөөд 2006 оны 12 сар, 2007 оны 12 сар, 2008 оны 5 сард тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Үүнээс харахад хэдхэн жилийн дотор 3 удаа бүрэн шинэчлэгдэж, маш олон удаа өөрчлөгдөж, хэд хэдэн багц хуульд хуваагдаж, үзэл баримтлалын хувьд тодорхой номлол болгон авчих зүйлгүй, өөрөөр хэлбэл амин сүнс нь хаана байгааг нь томъёолж, Та бүхэнд хүргэх чадвар надад л лав дутлаа. Энэ нь хуучин тогтолцооны үед олсон боловсролын чанарын тогтолцоог үндсэнд нь сулруулсан ч байж магад.

Үүнийг Дэлхийн Эдийн Засгийн Форумас гаргасан дэлхий дахины өсөлтийн өрсөлдөх чадварын 2005-2006 оны индекст дурдснаар Монгол Улс өсөлтийн өрсөлдөх чадварын ерөнхий индексээр 96-т орсон бол, Боловсролын тогтолцооны чанараар 67, боловсролд хамрагдалтаар 69, шинжлэх ухааны судалгааны чанараар 89, оюуны дайжилтаар 65, идэвх санаачлагыг урамшуулах цар хүрээгээр 90 байранд, бичиг үсэг тайлагдалт сүүлийн таван жилд 98-96 хувь болтлоо буурч Болив, Урагвай, Киргизийн дараа орсноос харж болно.

#### **“Зогсох газраа зогсох” буюу Эрх зүйн шинэтгэл**

Ер нь энэ бүхэн манайхны тодорхойлсон Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, түүнээс улбаалсан Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлүүдийг парламентын сонгуулийн нэг бүрэн эрхийн хугацаагаар хүрээ хязгаарыг нь томъёолж, тодорхойлчихсон байдаг гэж болно. Энэхүү тодорхойлсон хугацаандаа багтааж, өөрчлөх, шинээр боловсруулан батлах хууль тогтоомжуудаа жагсаагаад, түүндээ баригдаж хөтлөгдөн хатуухан хэлэхэд хүний, бүлгийн ашиг сонирхол дээр тулгуурлан ямар ч хамаагүй өөрчлөлт оруулах, амлалтаа гүйцээх зорилт тавьж ажилладгаас хамаарч хуулийн үйлчлэл, тогтвортой байдал алдагдаад байгаа гол хүчин зүйл юм. Иймээс шинэтгэл, шинэчлэлт, шилжилт, өөрчлөлт бүрт

зогсох цаг хугацаа гэж байдгийг санаж ажиллах хэрэгтэй мэт. Үүнийг солонгосын Ханкүк дугуйны реклам дээр хэлдэг шиг “**Зогсох газраа зогсох**” гэж томъёолж болно. Үүгээр юу илэрхийлэхийг хүсч байна гэвэл, манай Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр анхнаасаа алдаатай томъёологдож, эсхүл уг хөтөлбөр бодитоор хэрэгжээгүйгээс шалтгаалсан байж болох энэхүү үр дагавар, үр нөлөө хамаараад байгаа гэж шууд дүгнэх гаргалааг хийж болох байх.

Үүнийг тус индексээр манай улс хууль эрхийн хүрээний үр ашигтай байдлаар 111, төрийн зохицуулалтын дарамтаар 86, хууль тогтоох байгууллагуудын үр нөлөөтэй байдлаар 94, авилгаас бизнест учруулах зардалаар 88, шүүхийн хараат бус байдлаар 99-т тус тус орсон байгаагаас дүгнэхэд манай эрх зүйн зохицуулалт хэр оновчтой, тогтвортой бус байгааг илтгэж байна. өөрөөрхэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй гэх хуулийн хичнээн нь амин сүнсгүй, хий үзэгдлийн шинжтэйгээр тэнүүчилж буйгаас шалтгаалсан байж болох юм шүү.

#### **Системийн хямрал ба салбарын иноваци**

Нөгөөтэйгүүр хуулийн амин сүнс гэдэг нь ганц тухайн хуульд л хамаатай зүйл биш бөгөөд комплект байдлаар нэгээс нөгөө хуулиндаа шилжих замаар цогцоор хэрэгжих өвөрмөц зүй тогтол юм. үүнтэй холбоотойгоор нэг зүйлийг хэлэхэд манай улс Ром-германы эрх зүйн бүлд хамаарагддаг гэгдэн ихэнх хууль тухайн бүлд хамаарагдан боловсрогдсон байдаг. Гэвч иргэний эрх зүйн харилцааг зохицуулсан Иргэний хууль зэрэг хууль тогтоомжууд нь Эх газрын эрх зүйн системд үндэслэсэн, шууд үйлчлэлийн механизмтай байхад, санхүү, бизнесийн харилцааг зохицуулсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай зэрэг хууль тогтоомжууд нь Англо-саксоны, бүр далайн эрх зүйд үндэслэн зохицуулагдсанаас хамаарч **системийн хямралд** хүргэж байна.



Иймээс хуулийн амин сүнс гэх /Spirit of law/ ойлголт нь комплекс байдлаар шилжиж, цогцоор хэрэгждэг зүй тогтол гэж хэлж болох байна.

Учир нь улс орны эдийн засгийн болон хөгжлийн хурдасгуурт хуулийн салбарын шинэчлэгдэхгүй удааширсан байдал шууд нөлөөлж, хойш чирээд, чөдөрлөөд байгаа гол шалтгаан нь шүү.

Үүнээс шалтгаалан хууль тогтоомж хэрэгжихгүй байх, нийгэм, төрийн зүгээс түүнийг үл биелүүлэх, үл хүндэтгэх, үгүйсгэх үзэл нилээд байгаа бөгөөд энэ нь нэг талаас иргэдийн эрх зүйн ухамсрын төвшин доогуур, нөгөө талаас хуулийг хэрэгжүүлэх механизм боловсронгуй бус байна. Мөн хуулийг ямар нэгэн ид шидийн хүчин чадалтай мэт үзэж тулгамдсан бүхий л асуудлыг ганц далайлтаар шийдвэрлэх чадвартай хэрэглүүр гэсэн нийгмийн сэтгэлгээ ч дэлгэрэх хандлагатай байна. Энэ нь асар олон хууль тогтоомжууд шинээр батлагдаж, богино хугацаанд өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд иргэдээс хууль тогтоомжуудыг тухай бүр судлах, мэдээлэл авах, танилцах боломж тун хомс байгаатай холбоотойгоор нөгөө олон хуулийн амин сүнсүүд нь хоорондоо сүлжилдэн нисч, хий үзэгдлийн ертөнцийг ч бүрдүүлээд байж болзошгүй юм.

Иймээс энэхүү алдаатай, анзаардаггүй, хийхийг хүсдэггүй, хийх арга зүйн технологийг ойлгохгүй, нэвтрүүлэхгүй байгаа байдлыг нэн даруй халж, хуулийн салбарт **Иновацийн тогтолцоог нэвтрүүлэх** нь зүйтэй байна. Энэхүү зорилтоо хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засаг нь дараа дараагийн шатандаа орж хөгжих боломж бүрдэх болов уу.

**ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙН ТАЛААРХ  
ЭРХ ЗҮЙН ОРЧИН, НӨХЦӨЛ БАЙДАЛ**



**Б.Батцэцэг**  
**ХЭҮК-ын референт**

Сүүлийн жилүүдэд хүүхдийн үрчлэлт, түүнд тавих хяналт нь ихээхэн анхаарал татах болсон төдийгүй хүүхдийн дотоод гадаад үрчлэлтийн тоо өсөн нэмэгдэж байна. Хүүхдийн эрхийн аливаа төрлийн зөрчил, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгөөс хүүхдийг хамгаалах үр дүнтэй арга механизмын нэг бол тухайн улс дотоодын хууль тогтоомждоо үрчлэлтийг бүртгэх, үрчлэлтийн дараах хяналтыг хэрхэн зохицуулснаас ихээхэн хамаардаг.

Дотоодын болон гадаадын үрчлэлтэд тавигдах үндсэн шаардлага нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хүндэтгэн үзэх юм. Хүүхдийн дээд ашиг сонирхол гэдгийг тухайн хүүхдийг хүсэл сонирхлоос гадна, хүүхдэд чиглэсэн аливаа үйлдлийн үр дүн нь хүүхдийг эрхийн болоод сэтгэл санаа, ёс суртахууны хувьд ямар нэг бэрхшээлгүй, сэтгэл ханамжтай байдалтай болгосон байх гэж тайлбарлаж болно.

Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн<sup>1</sup> 21 дүгээр зүйлийн 21.1-д “үрчлэлтийн тогтолцоо бүхий болон түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсууд нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих бөгөөд тэдгээр нь:

<sup>1</sup> Монгол Улс 1990 онд соёрхон баталсан.

(a) хүүхдийн эцэг эх, төрөл садан, хууль ёсны асран хамгаалагч нарын зүгээс хүүхэд үрчлүүлэхийг зөвшөөрсөн, эсхүл дээрх сонирхогч хүмүүс шаардлагатай зөвлөгөө авсны үндсэн дээр үрчлүүлэх зөвшөөрлөө тодорхой мэдээлэлтэйгээр өгсөн, үрчлэлтэд хамаарах болон найдвартай эх үүсвэрээс авсан бүх мэдээллийг үндэслэн дагаж мөрдөж байгаа хууль, журмын дагуу гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүүхдийг үрчлүүлнэ;

(b) хэрэв хүүхдийн хүмүүжил буюу үрчлэлтийг хангаж чадахуйц гэр бүлд байлгах буюу хүмүүжүүлэх зорилгоор шилжүүлэх, эсхүл тухайн хүүхдийн төрсөн оронд зохих ёсоор нь асрамжлах боломжгүй бөгөөд өөр оронд үрчлүүлэх нь хүүхдийг асарч хамгаалах боломжтой арга хэмээн авч үзэж, хүүхдийг асран хамгаалалтад түр шилжүүлэх, тохирох гэр бүлд үрчлүүлэх, эсхүл эх оронд нь зохих ёсоор асран халамжлах боломжгүй бол үндэстэн дамнан үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрнө;

(c) хүүхдийг улс хооронд үрчлүүлэх тохиолдолд тухайн улсад хүүхэд үрчлүүлэхэд дагаж мөрддөг баталгаа болон хэм хэмжээг адил хэмжээнд хангана;

(d) улс хооронд үрчлүүлэх хүүхдийг шилжүүлэн суурьшуулахад оролцсон хүмүүс энэхүү үйл ажиллагаанаас санхүүгийн ашиг хонжоо олохгүй байх шаардлагатай бүх арга хэмжээ авна;

(e) энэ зүйлийн зорилтыг хангах үүднээс шаардлагатай бол хоёр талт буюу олон талт хэлэлцээр байгуулах, тэрчлэн хүүхдийг өөр улсад шилжүүлэн суурьшуулах ажлыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхийг зорино” гэж заажээ.

Дээрх Конвенциос гадна Монгол Улс 1998 онд нэгдэн орсон “Хүүхдийн эрхийг хамгаалах ба улс хооронд үрчлүүлэх асуудлаар хамтран ажиллах тухай” НҮБ-ын конвенци, Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль болон гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-аар үрчлэлтийн асуудлыг бүхэлд нь тус тус зохицуулж байна. Тус Гэр бүлийн хуулиар үрчлэгчид тавигдах шаардлагыг нарийн тодорхой хуульчилж өгсөн бөгөөд энэхүү зохицуулалт нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчилж авах хүсэлтэй гадаадын иргэдэд нэгэн адил хамаардаг болно.

Манай улсын хэмжээгээр 2008 оны байдлаар<sup>2</sup> албан ёсны зөвшөөрөл бүхий хүүхэд асрамж халамжийн 44 төв үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 19-ийг нь гадаадын 9 иргэн удирдан ажиллуулж байгаа бөгөөд тэнд амьдарч буй нийт 1364 хүүхдээс 666 нь эрэгтэй, 698 нь эмэгтэй хүүхэд байна. Энэхүү тоог дурдах болсон гол шалтгаан бол асрамж халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагаас хүүхэд үрчлэх боломжтой байдагт оршино.

#### **Гадаад үрчлэлтийн талаар**

Гадаадын иргэд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтэй байвал өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргах ба хүүхэд үрчлэн авахыг хүсэгчийн (нөхөр, эхнэртэй бол хамтарч гаргасан) хүсэлт, түүний нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны орчуулга; үрчлэгч нь сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаарх эмнэлгийн

<sup>2</sup> Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

магадлагаа, өргөдөл гаргагчийн гэрлэлтийн гэрчилгээний хуулбар (гэр бүлтэй бол); өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрын талаар холбогдох байгууллагын тодорхойлолт (цагдаагийн байгууллагын тодорхойлолт хамаарна); өргөдөл гаргагчийн амьдралын болон санхүүгийн боломжийн тухай тухайн улсын холбогдох байгууллагын тодорхойлолт зэргийг бүрдүүлдэг байна.

Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлд гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлыг зохицуулсан байна. Энэ зүйлд өргөдлийг хаана гаргах, бичиг баримтын бүрдэл, ямар байгууллага үрчлэлтийн асуудлыг 30 хоногт багтаан эцэслэн шийдвэрлэх талаар тодорхой тусгасан байна.

Гадаадад хүүхэд үрчлүүлэхэд тавигдах гол шаардлага бол үрчлэлт нь хүүхдийн дээд эрх ашигт нийцэж байгаа эсэх, хүүхэд худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт ашиглагдахаас сэргийлэх, хянах (үрчлүүлэх болон үрчилсний дараа) явдал юм. Иймээс хүүхдийг үрчлүүлсний дараах хяналтыг сайтар тавих шаардлагатай байдаг.

Манай улс 1999-2007 онуудын хооронд гадаадын 13 улсын иргэнд 171 хүүхэд үрчлүүлснээс 151 хүүхэд нь 2001-2007 онд үрчлүүлсэн байна. үүнээс үзэхэд жил тутам 20 гаруй Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэгдэн гадаадад гарч байгаа нь бага бус тоо юм.

2006-2008 онд нийт 63 хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлснээс 37 эрэгтэй, 26 эмэгтэй хүүхэд байсан ба эдгээрээс 2008 онд 29 хүүхдийг үрчлүүлсэн байна.<sup>3</sup>

<sup>3</sup> ГИХАЭА-аас гаргасан мэдээ 2009 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 1/58 тоот

Ийнхүү үрчлэгдсэн хүүхдийг журмын дагуу ГИХАЭГ нь хүүхдийн өсөлт бойжилт, хөгжлийн талаар хүүхдийг 1 сартайгаас 4 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл 2 жил тутам мэргэжлийн нийгмийн ажилтнаар хийлгэсэн үрчлэлтийн тайлан, мэдээлэл/ хүүхдийн өсч бойжиж буй фото зураг, видео бичлэг зэрэг/ авах, шаардлагатай гэж үзвэл үрчлэгдсэн хүүхдийн ахуй амьдрал, аж байдалтай үрчлэгч эцэг, эх болон зуучлагч байгууллагын зардлаар үрчлэгдсэн хүүхдийн оршин сууж байгаа газарт очиж танилцах арга хэмжээ авах, Монгол Улсаас үрчлэгчийн харьяалах улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт үрчлэгч эцэг, эх, үрчлүүлэгч хүүхдийн талаарх дэлгэрэнгүй судалгааг Гадаад хэргийн яамны консулын газраар дамжуулан хүргүүлж хяналт тавиулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

2008 онд ГИХАЭГ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран ХБНГУ-ын “Eltern Fur Kinder”, Итали Улсын “Amici Di Don Bosco”, 2006 онд АНУ-ын “Holt International”, “Lutheran Social Services” байгууллагуудаар зуучлуулж, Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсан ХБНГУ-ын харьяат үрчлэгч эцэг, эх үрчлэгдсэн хүүхдийн аж амьдрал, ахуй нөхцөлтэй газар дээр нь танилцаж, гэрэл зураг, видео бичлэг хийсэн байна.<sup>4</sup> Хүүхдийн амьдарч буй орчин нөхцөлтэй газар дээр нь очиж, танилцах ажиллагаа нь зардал хугацаа их шаарддаг тул тэр бүр эрх бүхий байгууллагаас явж, танилцах нөхцөл боломж хомс байдаг байна.

Хүүхдийн үрчлэлтийн асуудлыг “нууц” гэж ГИХАЭГ-аас үрчлэлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг өгөхөөс татгалзаж байгаа нь анхаарал татаж байна. Гэр бүлийн тухай хуулийн 60 дугаар зүйлд үрчлэлтийн нууцыг мэдэж байгаа албан тушаалтан, бусад

---

<sup>4</sup> ГИХАЭА-аас гаргасан мэдээ 2009 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 1/58 тоот

этгээд түүнийг хадгалах үүрэгтэй гэж заасан ба энэ нууцад чухам ямар мэдээлэл хамаарах нь тодорхой биш байна. Нөхцөл байдал ийм байгаагаас хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэд манай улсын хуулийн дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, ГИХАЭГ, гадаад оронд суугаа Монгол Улсын ЭСЯ, Дипломат төлөөлөгчийн газрууд гадаадад үрчлэгдсэн хүүхдийн талаар хэрхэн хяналт тавьж байгаа болон хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг дүгнэх боломж муу байна.<sup>5</sup>

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухайн хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д зааснаар Монголд Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэдэг. Гэтэл Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлж, харьяатаас гарах асуудлыг яам, агентлагийн хэмжээнд шийдвэрлэж байгаа цаашид анхаарах шаардлагатай асуудал гэж үзэж байна.

Гэр бүлийн тухай хуулийн 56 дугаар зүйлд “Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн хэмжээн дэх хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн судалгаа гаргаж, бүртгэл хөтөлнө. Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн нэгдсэн бүртгэл хөтөлж, хяналт тавина.” гэж заажээ. Харин энэ хуулиар үрчлүүлэх шаардлагатай хүүхэд гэдэгт ямар хүүхэд орох, ямар шаардлага тавигдах нь тодорхой бус байна. үрчлүүлэх шаардлагатай хүүхэд гэдэгт эцэг, эх, асран хамгаалагч харгалзан дэмжигч үрчлүүлэх хүсэлтэй байгаа хүүхдүүд, эцэг, эх нь тодорхойгүй, эсвэл эцэг, эх

<sup>5</sup> Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд судалгааны тайлан 2008он ХЭҮК, ОУХБ-Айпек

нь байсан ч гэсэн хүүхдээ асран хүмүүжүүлэх үүргээ биелүүлдэггүйгээс тэнэмэл амьдралд шилжсэн хүүхдүүд, хүүхдийн асрамж халамжийн газар, хүүхдийн албадан саатуулах газарт байгаа хүүхдүүдийг хамруулж болох юм. өөрөөр хэлбэл эдгээр хүүхдүүд нь худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт ашиглагдах, гэмт хэргийн хохирогч болох өндөр эрсдэлийг дагуулсан хүүхдүүд юм. Сум дүүрэг бүр ийм хүүхдийн бүртгэлтэй болж хөдөлгөөнд нь байнга хяналт тавьж ажилласнаар тухайн хүүхдийг худалдаалагдах, гэмт хэргийн хохирогч болох, алга болохоос урьдчилан сэргийлэх анхдагч нөхцлийг бүрдүүлэх нөхцөл болно.

Мөн Хүүхдийн эрхийн тухай конвенц болон “Хүүхдийн эрхийг хамгаалах ба улс хооронд үрчлүүлэх асуудлаар хамтран ажиллах тухай” НҮБ-ын конвенцид улс хооронд үрчлүүлэх хүүхдийг шилжүүлэн суурьшуулахад оролцсон хүмүүс энэхүү үйл ажиллагаанаас санхүүгийн ашиг хонжоо олохгүй байх шаардлагатай бүх арга хэмжээ авна гэж заасан. Гэтэл хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд хүүхдийн үрчлэн авч буй эцэг, эхчүүдээс урамшуулал авах, тэнд асруулж буй хүүхдүүдийн нэр төр, эмзэг байдлыг ашиглан донор хувь хүмүүс болон байгууллагуудаас санхүүжилт авдаг гэх мэдээлэл олон нийтийн дунд тархаад байгаад анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т Монгол Улсад зургаан сараас доошгүй хугацаанд оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авахад “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам” бус дотоодын үрчлэлтийн адилаар хүүхэд үрчлэх талаар зохицуулсан нь анхаарал татаж байна.



Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 2 дугаар зүйлд “Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана” гэж заасан ч “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-ын 8 дугаар зүйлд ганц бие эцэгт үрчлүүлэхгүй байхаар зохицуулжээ.

Мөн Гэр бүлийн тухай хууль болон “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-д удаа дараа гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүүхдийг үрчлүүлэхгүй байхаар зохицуулжээ. Удаа дараа гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 3 ба түүнээс дээш удаагийн гэмт үйлдэл үйлдсэн этгээдийг ойлгодог тул тухайн этгээд давтан гэмт хэрэг үйлдсэн байх нь хувийн зан байдлын хувьд хүүхэд өсгөх, тэжээн тэтгэх боломжгүй болохыг илтгэх хангалттай үзүүлэлт гэж үзэж байна.

### **Дотоод үрчлэлтийн талаар**

Дотоодод хүүхэд үрчлүүлэх журмыг Гэр бүлийн хуулиар бүхэлд нь зохицуулсан бөгөөд хуулийн зохицуулалтын дагуу хүүхэд үрчлэхийг хүсэгч нь тухайн сум дүүргийн засаг даргад хүсэлтээ гаргах бөгөөд Засаг дарга хүсэлтийг хянаж, үзээд 20 хоногт багтаан шийдвэр гаргаж, иргэний бүртгэлийн ажилтан үрчлэлтийг бүртгэж авдаг байна.

Өмнө дурдсанчлан Хүүхдийн эрхийн конвенцийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “үрчлэлтийн тогтолцоо бүхий болон түүнийг хүлээн

зөвшөөрсөн оролцогч улсууд нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих бөгөөд тэдгээр нь хүүхдийн эцэг эх, төрөл садан, хууль ёсны асран хамгаалагч нарын зүгээс хүүхэд үрчлүүлэхийг зөвшөөрсөн, эсхүл дээрх сонирхогч хүмүүс шаардлагатай зөвлөгөө авсны үндсэн дээр үрчлүүлэх зөвшөөрлөө тодорхой мэдээлэлтэйгээр өгсөн, үрчлэлтэд хамаарах болон найдвартай эх үүсвэрээс авсан бүх мэдээллийг үндэслэн дагаж мөрдөж байгаа хууль, журмын дагуу гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүүхдийг үрчлүүлнэ” гэж заасан.

Гэтэл Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй үйл ажиллагааны зөвшөөрөл авсан төрийн болон хувийн хэвшлийн 48, зөвшөөрөл аваагүй 4 хүүхдийн асрамж үйлчилгээний төвүүдэд 1494 хүүхэд асрамжлуулж байгаагийн 550 нь бүтэн өнчин, 664 нь хагас өнчин, 280 нь орон гэргүй хүүхдүүд байна.<sup>6</sup> Дээрх асрамж үйлчилгээний төвүүдэд асрамжлуулж байгаа хүүхдүүдийг үрчлүүлэхдээ бүтэн өнчин, хагас өнчин, эцэг эхтэй хүүхэд байх эсэхээс үл хамаарч зөвхөн асрамжийн газрын гаргасан судалгаан дээр үндэслэн хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг авахгүй, мөн тэдэнд мэдэгдэлгүйгээр тухайн сум дүүргийн засаг даргын захирамжийн дагуу үрчлүүлж байгаа нь учир дутагдалтай юм.

Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн болон буяны байгууллагууд ихээр байгуулагдах болсон нь хараа хяналтгүй хүүхдийн тоо буурах, тэднийг аливаа эрсдлээс хамгаалахад нэн тустай хэдий ч хараа хяналтгүй хүүхдүүдийг хүлээн авахад шаардагдах бичиг баримтын бүрдүүлэлт

<sup>6</sup> Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар “Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад хийсэн хяналт шинжилгээний нэгдсэн тайлан” 2007 он

шаардахгүйгээр хүүхдүүдийг хүлээн авснаас хүүхдийн үрчлэлтэд тавигдах хяналт хэт эмх замбараагүй болоход хүрч байна.

Түүнчлэн үрчлүүлсэн хүүхэд ямар нөхцөлд хэрхэн амьдарч байгааг хянах ажлыг Хүүхдийн төлөө газар хариуцан ажилладаг боловч сүүлийн 3 жилд энэ талаар тодорхой үйл ажиллагаа хийгээгүй ба дотоод үрчлэлтийн талаарх мэдээлэлгүй байна. Энэ нь үрчлэгдсэн хүүхдүүдийн эрх ашгийг хангалттай хэмжээгээр хамгаалахад анхаарал тавихгүй байгаагийн илрэл юм. 2008 онд 2337 хүүхдийг, 2009 оны 1 дүгээр улиралд 160 хүүхдийг Монгол Улсын иргэнд үрчлүүлснийг бүртгэлийн байгууллага бүртгэжээ.<sup>7</sup> Ийм олон тооны хүүхдийн ямар нөхцөлд амьдарч байгааг нь хянахгүй өнгөрөөж байгаа нь ирээдүйд ямар сөрөг үр дагаврыг бий болгож болохыг тооцож, цаашид анхаарч ажиллах шаардлагатай юм.

2008 онд Нийслэлийн хэмжээнд үрчлэлтийг хүчингүйд тооцуулах талаар нийт 20 гаран нэхэмжлэл хүлээн авсанаас 17-г нь хангаж, шийдвэрлэсэн байна.

Иймд цаашид гадаад улсын иргэнд үрчлүүлсэн хүүхэд хүний худалдааны хохирогч болох эрсдэлтэй гэхээсээ илүүтэйгээр дотоодод үрчлүүлсэн хүүхэд энэхүү эрсдэлд өртөж болзошгүйг анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

Түүнчлэн хүүхдийг үрчлэх ялангуяа өсвөр насны хүүхдүүдийг үрчлэн авч боолын хөдөлмөр эрхлүүлэх, албадан хөдөлмөрлүүлэх явдал гарч болзошгүй талаар холбогдох албаны хүмүүс цаашид онцгой анхаарч ажиллах хэрэгтэй юм.

<sup>7</sup> ИБМУТ-ээс авсан мэдээ 2009 оны 3дугаар сарын 16-ны өдөр

**Санал дүгнэлт:**

Дээр дурдсан зүйлүүдэд үндэслэж дараах санал дүгнэлтийг гаргаж байна. Үүнд

1.Хүүхдийн үрчлүүлж байгаа тохиолдолд эцэг эх байх эрхээ хасуулснаас бусад тохиолдолд хүүхдийн эцэг эх, цагдаа, асрамжийн газрын ажилтнуудыг оролцуулан албан ёсны зөвшөөрлийг нь авч байх,

2.Хүүхдийг дотоодод үрчлүүлэх асуудлыг тухайн шатны засаг дарга бус, асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцаж байх,

3.Хүүхдийн гадаадын иргэдэд үрчлүүлсэн тохиолдолд эх оронд нь тодорхой хугацааны давтамжтайгаар ирүүлж, соёл уламжлалтайгаа танилцах зохицуулалтыг шинээр хууль болон журамд нэмж хуульчлах,

4.Дотоодын үрчлэлтийн талаар төрийн байгууллагуудын мэдээллийн сүлжээг бий болгож, хүүхдийн амьдарч буй орчин нөхцөлийн талаар 1 жилийн давтамжтайгаар хяналт тавьдаг эрх зүйн орчинг бий болгох.

**БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ**



**Г.Оч**  
**ХЭҮК-ын референт**

Сүүлийн 30 гаруй жилийн туршид дэлхийн эдийн засаг даяаршихын хэрээр үндэстэн дамнасан корпорац, бизнесийн байгууллагууд олноор үүсэн бий болж, тэдгээрийн үйл ажиллагааны хамрах цар хүрээ улам өргөжин тэлсэн билээ. Эдгээр бизнесийн байгууллагуудын хүний нөөц нь зарим тохиолдолд жижиг улс орны хүн амтай тэнцэх хэмжээнд хүрсэн нь уг асуудалд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс анхаарал тавин ажиллах цаг болсныг илтгэж байна. 2007 оны байдлаар дэлхийн нийтийн корпорациудын жилийн ашиг орлого нь дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 11 хувийг эзэлсэн нь уг байгууллагуудад их хэмжээний эрх мэдэл төвлөрч байгааг нотлож байна.

Ихэнх тохиолдолд хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих нь зөвхөн тухайн орны төр засгийн үүрэг хариуцлага гэж ойлгодог. Хэдийгээр аливаа орны төр засаг түүн дотор засгийн газар нь хүний эрхийг хангах нэн тэргүүний үүрэг хариуцлагыг үүрдэг боловч энэ нь хувийн хэвшлийг нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаас чөлөөлж байгаа хэрэг биш юм.

Хувийн хэвшлийн хүлээх нийгмийн хариуцлагын асуудлыг ярилцахад юуны түрүүнд тэдгээр байгууллагуудын хийж гүйцэтгэж болох зүйлс буюу тэдгээрийн нөлөөллийн хүрээг тодорхойлох нь маш чухал байдаг. Нөлөөлийн хүрээ гэсэн ойлголт аливаа олон

улсын хэм хэмжээнд тэр болгон тусгагдаагүй байдаг хэдий ч энэ нь тухайн бизнесийн байгууллагын өөрийн бодлого, хамтын ажиллагаа, үйл явц, цар хүрээ, байрлал зэрэг олон хүчин зүйлүүдийг бодолцон хүний эрхийг хангах боломжийн хүрээ гэж ойлгож болох юм. Иймд тухайн аж ахуй нэгжийн том жижгээс үл хамааран түүнд тодорхой хэмжээний нөлөөллийн хүрээ байдаг. Нөлөөллийн хүрээг дараахь үндсэн байдлаар тодорхойлж болно. үүнд:

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нарийн хяналт тавин ажиллах. Тодруулбал, өөрийн ажилчдад хөдөлмөрийн хэм хэмжээ, норм стандартыг мөрдүүлэхээр нягт нямбай хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаа явуулж буй газрын уугуул иргэд, оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчихгүй байх.

2. Хүний эрхийг бусадтай хамтран хамгаалах, хэрэгжүүлэх. Уг алхамыг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа хяналт тавин, хүний эрхийг хангасны дараа хийгдэх хоёр дугаар шатны үйлдэл гэж ойлгож болох юм. Бусад оролцогчид, түнш, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч, бизнесийн холбоод хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллан, хүний эрхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

3. Бизнесийн байгууллагууд үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүнээ юунд хэрэглэгдэж буйд анхаарал тавих. Үүнд дарангуйлалт засаглал бүхий газар ашиглагдаж буй зэр зэвсэг, тоног төхөөрөмж, түлш, эрчим хүч зэрэг зүйлс орж болох юм.

4. Хүний эрхийг хангах, хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн таатай орчин бий болгох санхүүгийн туслалцаа үзүүлэх. Энэ үйл ажиллагаа нь нийгмийн болон нийгмийн анхаарал татсан бүлгийн ашиг тус, сайн сайхны төлөө өөрийн ашгийн тодорхой хэсгийн хувиарлахад чиглэнэ.

Мөн эдгээр үйлдлээс гадна бизнесийн байгууллагууд хүний эрхийн зөрчил гарахад шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг. Энэ нь хүний эрхийн зөрчил гаргаж буй этгээдэд шууд болон шууд бус байдлаар тусламж дэмжлэг үзүүлэх, итгэл үл даах хүлээсэн үүргээ биелүүлэхдээ зөрчил гаргах хандлагатай этгээд, засгийн газар, компанитай гэрээ байгуулан ажиллахгүй байх, аливаа хүний эрхийн зөрчлөөс ашиг олохгүй байх, хүний эрхийн тогтмол зөрчилд хариу арга хэмжээ авахгүй байх зэрэг байдлаар хүний эрхийн зөрчил гарахад шууд болон шууд бусаар нөлөөлж болох юм.

Эдгээр үйлдүүдийн жишээг дурдвал, Судан Улсын хямралт байдлыг арилтал Роллс ройс компани Судан Улсын компаниудад хөдөлгүүр нийлүүлэхээ түр зогсоосон байна. Мөн Форд компани өөрийн үйлдвэрлэсэн машинуудыг цэргийн болон зэвсэгт бүлэглэлүүд ашиглах боломжтой гэж үзсэний үндсэн дээр 2007 оноос эхлэн Судан Улс руу машин экспортлохоо зогсоосон байна.

Бизнесийн байгууллагуудыг хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажилд хамруулан оруулах арга механизм нь сайн дураар мөрдөх журам батлан, түүнийг мөрдөх, эсвэл хуулиар тогтоосон албадлагын шинжтэй зүйл, заалт баримтлах гэсэн хоёр зохицуулалтаас бүрдэх бөгөөд эдгээрийн аль нь шалгарсан шилдэг арга болох талаар маргаан өрнөсөөр байна. Иймд тус бүрийн давуу болон сул талыг тодорхойлох нь нэн чухал.

Сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаа, ажиглалтаас үзэхэд бизнесийн байгууллагууд болон засгийн газруудын үзэж байгаагаар хуулийн зүйл заалтаар албадсан зохицуулалтаас илүү сайн дураар мөрдөх дүрэм журам бий болгон, түүнийг мөрдөх нь аж ахуй нэгжийн үйл ажиллагааны горим, хандлага болон хүний эрхийг хамгаалах

ажилд үр дүн гарахад илүү нөлөө үзүүлдэг гэсэн дүгнэлтэнд хүрсэн байдаг.

Сайн дураар мөрдөх журмын давуу талууд дараахь байдлаар илэрдэг. Үүнд:

1. Хуулиар болон хуулийн зохих зүйл заалтаар албадсан аливаа зохицуулалт тэр болгон амьдралд буюу бодит байдалд нийцдэггүйн улмаас зөрчилдөөн, үйл ойлголцох байдал үүсч, улмаар хууль бус бизнесийн үйл ажиллагаа үүсэх хүчин зүйл болох магадлал ихтэй байна. Үүний нэг жишээ бол АНУ-д 1920-иод оны үеэд согтууруулах ундааны эсрэг хууль батлагдсаны улмаас хууль бус наймаа, мөнгө угаах зэрэг далд бизнес цэцэглэн хөгжих нөхцөл бүрэлдсэн гэж үздэг.

2. Сайн дураар мөрдөх журам нь аж ахуй нэгж, бизнесийн байгууллагууд өөрийн байгууллагыг сурталчилах, шинэ хамтрагч олох, олон улсын түвшинд идэвхитэй үйл ажиллагаа эрхлэхэд олон нийтийн харилцаа буюу бидний нэрлэж заншсан PR-аа өсгөн дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлөх боломжийг бий болгож байна.

3. Хууль болон хуулийн зүйл заалт нь аливаа асуудлыг ерөнхийлөн зохицуулж байдагтай холбогдон, олон тооны салбарт хүч сорин ажиллаж байгаа бизнесийн байгууллага бүрт нэгэн хэвийн үүрэг, шаардлага тавьдаг бөгөөд үүнтэй уялдан дахин зөрчилдөөнт байдал үүсч болох тул хуулийн зохицуулалтыг нарийвчлан боловсруулах шаардлага тулгардаг. Харин сайн дурын журмын нэг онцлог нь маш уян хатан, тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн тохируулсан байдлаар боловсруулах боломжтой байдаг.



4. Олон улсын хэм хэмжээ, норм стандартыг хувийн хэвшлийн байгууллагуудаар биелүүлэн, сахиулах нь маш хэцүү байдаг. Тодруулбал, олон улсын норм, хэм хэмжээ нь хууль тогтоомжтой адил хэт ерөнхий байдлаар асуудлыг хөнддөг учраас тухай бүр амьдралд хэрэгжүүлэхэд бэрхшээл, саад учирдаг тул түүнийг сахиулах нь абстракт зүйл юм.

5. Хуулиар тогтоосон хариуцлагын, тэр дундаа торгуулийн хэмжээ нь зарим тохиолдолд хэт бага учир аливаа өөрчлөлт хийх, үр нөлөө гаргах, хүмүүс өөрийн хандлагыг зөв зүг рүү чиглүүлэхээс илүүтэй хялбар, амар, төвөггүй торгуулийг төлдөг нь үр нөлөөгүй, хэрэгцээгүй хуулиуд үйлчилдэг байдал газар авах хандлагатай байна.

Сүүлийн арван жилд ерөнхий болон үйлдвэрлэлд хамааралтай сайн дураар мөрдөх олон журам бий болжээ. Тэдгээрийн хамгийн өргөн цар хүрээг хамарсан нь НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact) бөгөөд 2002 онд хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр үүсэн бий болсон сайн дурын санаачилга юм. Одоогоор уг гэрээнд 2300 гэрээний талууд буюу компаниуд нэгдэн орсон байна. Даян дэлхийн гэрээнд хүний эрх хангах, сайн хөдөлмөрийн нөхцөлийг бий болгох, байгаль орчинг хамгаалах, авлигалтай тэмцэхэд чиглэсэн 10 зарчмаас бүрддэг. Байгууллага бүр дээрх зарчмуудад чиглэсэн үйл ажиллагааны тайланг жил болгон хүргэн мэдээлэх журамтай байдаг.

Харин эсрэгээр хуулиар албадсан зохицуулалтын үр нөлөө, давуу талуудын талаар дараахь зүйлийг тодорхойлж болох юм. Үүнд:

1. Хүний эрхийн хэм хэмжээг сахиулан биелүүлэх нь бизнесийн хувьд их хэмжээний ашиг олох тэмүүлэл бүхий сайн дурын санаачилга, ашиг сонирхолтой зөрчилдөх байдал түгээмэл гардаг тул тэр болгон байгууллагууд сайн дураар хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих сонирхол бага байдаг учраас тодорхой хэмжээний байгууллагууд дэмжих байдал ховор тохиолдоно.

2. Сайн дурын санаачилга нь шинэ төрлийн зохицуулалтын үр нөлөө, цар хүрээг тодорхойлон шалган турших чухал нөлөө үзүүлдэг байна.

3. Түүхэн баримтаас үзвэл сайн дураар мөрдөх байдал дан ганцаар хүний эрхийг хангаж чадахгүй бөгөөд дэлхий 2 дугаар дайны үеэр гарсан хүний эрхийн зөрчлүүд олон хүний эрхийн эрх зүйг бий болгоход нөлөөлсөн юм.

4. Сайн дурын дүрэм нь сайн санааны үндсэн дээр бий болдог тул хэт их эрх чөлөөтэй байдал үүсгэн сул хараа хяналтгүй байдлыг бий болгох хүчин зүйлс болох эрсдэлтэй байдаг.

Дээрхи нөхцөл байдалд аливаа орны засгийн газрын зүгээс авах арга хэмжээ, үүрэг оролцоо маш чухал бөгөөд хүний эрхийг хангах үүргийн хувьд гуравдагч этгээд буюу хувийн хэвшлийн зүгээс хүний эрхийн зөрчил гаргахгүй байх тал дээр анхаарал тавих шаардлага зүй ёсоор үүсэн гарч байна. Иймд уг нөхцөл байдалд идэвхитэй байр суурь эзлэн өөрийн оролцоог идэвхжүүлэх нь засгийн газрын зүгээс хийх нэн тэргүүний алхам байх ёстой. Уг асуудлуудыг дараах ерөнхий байдлаар тодорхойлж болно. Үүнд:

·Нийгмийн өмнө хувийн хэвшлийн хүлээсэн хариуцлага болон тогтвортой байдлыг хөхиүлэн дэмжиж, нийгмийн ашиг тусын төлөө үйл ажиллагааг байгууллагууд өөрийн нөлөөлийн хүрээнд явуулах, мөн нийгмийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах.

·Уг үйл ажиллагааны хүрээнд хийсэн ажлыг үнэлэх шалгуур, уралдаан зохион байгуулах, түүнийг хараат бус байдлаар урамшуулах нь уг ажлыг зоригжуулан дэмжихэд үлэмж нөлөө үзүүлэх.

·Хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор хийсэн ажлын албадан тайлагнах тогтолцоог бий болгох.

·Хүний эрхийг сахиулахтай холбоотой хувийн хэвшлийн олон улсын санаачилгатай холбогдуулж, хууль тогтоомжоо шинэчлэн өөрчлөх, батлах зэрэг олон төрлийн үйл ажиллагааг идэвхитэй явуулснаар олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх, эрх чөлөөг баталгаажуулах, сахиулан хамгаалах үйлст засгийн газар идэвхитэй оролцож, хүний эрхийн ээлтэй орчин, нөхцөл байдал бий болгох боломж байна.

Дээр дурдсан хоёр төрлийн зохицуулалтыг харилцан судалж, тус бүрийн давуу талыг ашиглан зохицуулалт хийх нь хувийн хувилд хүний эрхийн асуудлыг хөндөн оруулах нь нийгмийн ашиг сонирхол, түүнийн хэрэгцээнд дээрх 2 зохицуулалтын холимог хувилбарыг ашиглах нь зөв шийдэл болно. Иймд хуулиар албадах зохицуултыг илүү боловсронгуй болгож, сайн дурын санаачилгыг шалгуурын дээд түвшин харин хуулиар албадсан зохицуулалтыг зайлшгүй байх доод түвшинг болгон тогтоож өгөх боломж байгаа болно.

Бизнесийн нийгмийн хариуцлагын жишээнээс дурдвал, Энэтхэгийн хамгийн том аж ахуй нэгжийн нэг болох ТАТА групп нь өөрийн орлогын 30%-ийг нийгмийн хөгжлийн хөтөлбөрүүдэд зарцуулдаг байна. Тэдгээр хөтөлбөрүүдийн нэг нь ДОХ/ХДХВ-тэй тэмцэхэд чиглэгдсэн бөгөөд үүний үр нөлөөнд тухайн хөтөлбөр хэрэгжсэн бүсэд дээрх өвчний тохиолдол буурсан болохыг ДОХ-той тэмцдэг дэлхийн томоохон 100 аж ахуй нэгжүүдийг нэгтгэсэн Даяар Бизнесийн Эвсэл хэмээх байгууллага хүлээн зөвшөөрчээ.

Мөн АНУ-ын авто машин үйлдвэрлэгч Форд компани Судан Улсад болж буй зэвсэгт мөргөлдөөний асуудалд анхаарал тавин, тус бүсэд өөрийн тоног төхөөрөмжийг дайны зориулалтаар ашиглах боломж бололцоо байгаа болохыг харгалзан үзэж, өөрийн тоног төхөөрөмж, сэлбэг нийлүүлэхээ зогсоосон туршлага бий.

Иймд бизнесийн байгууллагуудын хүлээх нийгмийн хариуцлагыг бий болгох, түүнийг хөгжүүлэн боловсронгуй болгох, хүний эрхийн аливаа зөрчил гаргуулахгүй байх үүднээс дээрх арга хэрэгслийг хослуулан, үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, үйлдвэрчэний эвлэлүүд зэрэг олон байгууллагуудын үүрэг оролцооноос гадна тухайн аж ахуй нэгжийн хүсэл зориг, хамтын ажиллагаа онцгой үүрэгтэй билээ.

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГТ ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН  
ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ**

**Э.Энхжаргал**  
**МУИС, ХЗС-ийн магистрант**

1992 онд Үндсэн хууль шинэчлэгдсэн батлагдсанаар эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийн тулд эрх зүйн шинэтгэлийн ажил эрчимтэй өрнөж байгаагийн нэг тод жишээ бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулиудыг 2003 онд Улсын Их Хурлаас баталж, 2004 оны 6 дугаар сарын 1 -нээс Захиргааны хэргийн шүүх байгуулагдан ажиллах болсон явдал юм. Ингэснээр иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг захиргааны хууль бус буюу дур зоргын үйл ажиллагаанаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх боломжтой болсон билээ. Хэдийгээр иргэн, хуулийн этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой болсон хэдий ч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ЗХХШтХ гэх/ - д зөрчилдөөнтэй заалтууд байгаа бөгөөд цаашид энэхүү хуулийг улам боловсронгуй болгох нь эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх гэж буй иргэн, хуулийн этгээдэд ашигтай юм.

**Монгол улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:** Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлд захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагансан шүүхийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөн хуульчилсан. Иймээс ч захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг Улсын Их Хурал

2003 онд баталж, захиргааны хэргийн шүүх 2004 оны 6 дугаар сарын 1 –нээс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

ЗХХШтХ –ийн 15 дугаар зүйлд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харъяаллын талаар зохицуулсан бөгөөд тэрхүү зохицуулалтаас харахад захиргааны хэргийн 3 шатны шүүх байх ба аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Харин Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим анхан шатны журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийг давж заалдах шатны, Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн болон анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхээр байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим нэг талаас давж заалдах шатны шүүхийн харъяаллаар анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй хэргийг хянаж байгаа бол нөгөө талаас анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалтай хэргийг хяналтын шатны шүүхийн харъяаллаар хянаж байгаа хэрэг юм. Энэхүү зохицуулалт нь Монгол улсын үндсэн хуулийн 50 дугаар зүйлд заасан Улсын Дээд шүүх нь давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх бүрэн эрхтэй холбоотой юм.

Анхан шатны шүүх буюу аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх захиргааны акттай холбоотой нэхэмжлэлийг хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулан шийдвэр гаргадаг..

Давж заалдах шатны шүүх буюу УДШ-ийн Захиргааны хэргийн танхим давж заалдах журмаар гомдол гаргасан хэргийг 3 шүүгчийн

бүрэлдэхүүнтэйгээр хянан хэлэлцэж магадлал гаргадаг. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцсэн байх бөгөөд уг хуулиар хэлбэрийн шаардлага тавьсан байх бөгөөд давж заалдах гомдол гаргах үндэслэлийн талаар зохицуулалт байдаггүй.

Хяналтын шатны шүүх буюу УДШ-ийн Захиргааны хэргийн танхим хяналтын журмаар гомдол гаргасан хэргийг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан хэлэлцэж тогтоол гаргадаг. Хяналтын журмаар гомдол гаргахдаа шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, мөн хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэдэг үндэслэлээр гаргах бөгөөд хяналтын шатны шүүх энэ үндэслэлийг хянах үүрэгтэй байдаг.

ЗХХШТХ –иар давж заалдах журмаар гомдол гаргах хуулийн тодорхой босго тавьж өгөөгүй харин хяналтын журмаар гомдол гаргахад Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай адилаар зохицуулсан байна.

ЗХХШТХ –д давж заалдах журмаар гомдол гаргах хугацааг хоёр өөрөөр зохицуулсан бөгөөд эдгээр нь хоорондоо зөрчилдөж байна. үүнд: 77 дугаар зүйлийн 77.2 –т “Нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш **14** хоногийн дотор давж заалдах гомдол ... бичиж болно” гэж заасан бол 81 дүгээр зүйлийн 81.1 –д “анхан шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлээд гаргасан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, эсхүл тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гардуулсан буюу энэ хуулийн 72.3 –

т заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш **10** хоногийн дотор давж заалдах гомдлоо Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргах эрхтэй” гэж заасан байна. Гэхдээ практикт давж заалдах журмаар гомдол гаргах хугацааг шүүхийн шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 14 хоногоор тоолж байна. Магадгүй ингэж хоёр өөр байгаа нь хэн нэг этгээдийн хариуцлагагүй байдлаас болж техникийн талаас алдаа гаргасан байхыг үгүйсгэх аргагүй юм.

ЗХХШтХ –ийн 77 дугаар зүйлийн 77.3 –т “анхан шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эсэхээ сонгон гомдлоо захиргааны хэргийг шийдвэрлэсэн тухайн шүүхэд ирүүлнэ” гэж заасан. Эндээс харахад хэргийн оролцогчид анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан аваад давж заалдах шатны шүүхийг алгасаад хяналтын шатны журмаар гомдол гаргах эрх нээлттэй байна. Ингэж гомдол гаргахад шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, мөн хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэдэг үндэслэлээс өөр босго буюу тусгай ямар нэгэн урьдчилан нөхцөл шаардагдахгүй байна. Тэгвэл хэргийн оролцогчдын аль нэг тал нь дээрх үндэслэлүүдийн аль нэгээр шууд хяналтын шатны шүүхэд гомдол гаргахад хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгч талын хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл бүрдэж байна. Учир нь хяналтын журмаар анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлээд гаргасан шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах эрхгүй гэж ЗХХШтХ –ийн 77 дугаар зүйлийн 77.5 –д заасан байна. ХБНГУ –ын захиргааны шүүхийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.2 –т алгассан хяналтын тухай зохицуулсан



байдаг ба анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргахгүйгээр шууд алгасаж хяналтын журмаар Холбооны захиргааны шүүхэд гомдол гаргахад нэхэмжлэгч болон хариуцагч талын бичгээр өгсөн зөвшөөрөл шаардлагатай байдаг байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг шууд Улсын Дээд шүүхийн хяналтын шатанд хянуулж болохоор Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нь хэргийн оролцогч талуудын эрхийг шүүхийн бүхэл бүтэн нэг шатаар хохироож байгаа хэрэг юм.<sup>1</sup> Эрүү болон иргэний хэргийн хувьд анхан шатны шүүхийн шийдвэрт заавал давж заалдах шатны журмаар давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах бөгөөд уг гомдлыг шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар Улсын Дээд шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлдэг. Тэгтэл захиргааны хэргийн хувьд давж заалдах шатыг алгасаад шууд хяналтын журмаар гомдол гаргаж буй нь эрх зүй өндөр хөгжсөн ХБНГУ –тай адил хэдий ч манай улсын ЗХХШтХ –д хийдэлтэй зохицуулсан байна. ХБНГУ –ын захиргааны шүүхийн тухай хуулинд кассацийн буюу алгассан хяналтын талаар нарийвчилсан олон зохицуулалтууд байдаг.

Захиргааны хэргийн хувьд давж заалдах журмаар гомдол гаргаж захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхээр хянуулах нь хэргийн оролцогчдод зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо дээд шатны шүүхээр хамгаалуулах өргөн боломж олгох ба хяналтын журмаар хянуулахаас давуу талтай юм.

**ХБНГУ –ын захиргааны шүүхийн тухай хуулийн зохицуулалт:**  
ХБНГУ –ын үндсэн хуулийн 93, 95 дугаар зүйлүүдэд дагнасан шүүхийг хүлээн зөвшөөрч, бүтэц тогтолцоог үндсэнд нь тодорхойлж

<sup>1</sup> Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. 2009, УБ., 63 дахь тал

өгсөн байдаг. Германы захиргааны хэргийн анхны шүүх 1863 онд Баден мужид байгуулагдсан түүхтэй ч орчин цагийн тогтолцоо нь Дэлхийн II дайны дараа буюу 1946-1947 онуудаас бүрэлдэн тогтсон байна.<sup>2</sup>

ХБНГУ –ын захиргааны шүүхийн тухай хуулийн<sup>3</sup> 2 дугаар зүйлд захиргааны хэргийн шүүхийн тогтолцооны талаар зохицуулсан байна. ХБНГУ-ын захиргааны шүүх нь 3 шаттай бөгөөд анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх буюу мужийн захиргааны хэргийн шүүх, хяналтын шатны шүүх буюу Холбооны захиргааны хэргийн шүүх байна.

Анхан шатны шүүх захиргааны маргаантай аливаа гомдлыг хүлээн авдаг. Анхан шатны шүүх буюу захиргааны танхим нь 5 шүүгчээс бүрдэх бөгөөд 3 шүүгч нь мэргэжлийн, 2 шүүгч нь туслах шүүгч байдаг.

Хоёр дахь шат буюу давж заалдах мужийн шүүх нь гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр захиргааны маргааны хянан хэлэлцдэг. Тус шүүх нь давж заалдах гомдлоор хэрэг хянахаас гадна хуульд заасан үндэслэл байвал зарим төрлийн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Тухайлбал, Захиргааны шүүхийн тухай хуулийн 48 дугаар зүйлд зааснаар, атомын цахилгаан станц барих зөвшөөрөл болон зам тээвэр зэрэг томоохон объектоор холбоотой маргаан багтаж байна. Мужийн шүүх нь мөн захиргааны шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу

<sup>2</sup> “Захиргааны хэргийн шүүх” цуврал гарын авлага №6, Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх. . 2005. УБ., 8 дахь тал

<sup>3</sup> Закон об административном суде германий, Verwaltungsgsgerichtsdordnung (VwGO), 1995

мужийн хуулийн доод шатны хууль тогтоомжийг хянах эрхтэй байдаг байна.<sup>4</sup>

ХБНГУ –д захиргааны шүүхийн шийдвэрийг давж заалдах нь 1996 оноос хойш гагцхүү шүүхээс зөвшөөрөгдсөн тохиолдолд хэрэгжих боломжтой болсон. Энэхүү “зөвшөөрөгдсөн гомдол” –ын зарчим нь захиргааны процессыг хялбарчлахын тулд хийгдсэн шинэчлэлийн үндсэн элемент болж байгаа юм. Ийм онцгой зөвшөөрлийг захиргааны шүүхийн тухай хуулийн 124-р зүлд заасны дагуу анхан шатны шүүхийн шийдвэрээр, эсхүл оролцогчдын аль нэгний хүсэлтээр давж заалдах шатны шүүх олгоно. Холбогдох хүсэлтийг татгалзсанаар анхан шатны шүүхийн шийдвэр нь хүчин төгөлдөр болдог байна.<sup>5</sup>

ХБНГУ-ын захиргааны шүүхийн тухай хуулийн 124.2 –т заасан дараахь таван үндэслэлийн аль нэг нь байгаа тохиолдлд л давж заалдах шатны шүүхээр гомдлыг хянан шийдвэрлэнэ:

1. Шүүхийн шийдвэр зөв болох нь эргэлзээтэй бол
2. Маргаан нь бодит байдал болон эрх зүйн хувьд онцгой хүндэрлтэй байгаа бол
3. Маргаан нь зарчмын шинжтэй бол
4. Шүүхийн шийдвэр нь дээд шатны шүүхийн шийдвэртэй зөрчилдөж байвал
5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа алдаатай явагдсан хэмээн гомдол гарвал

<sup>4</sup> “Захиргааны хэргийн шүүх” цуврал гарын авлага №6, Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх. 2005. УБ., 9 дэх тал

<sup>5</sup> Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 2004. УБ., 228 дахь тал

Хяналтын шатны шүүх буюу Холбооны захиргааны хэргийн шүүх нь таван шүүгч бүхий хэд хэдэн сенатуудаас бүрдэнэ. Эдгээр сенатууд нь эрх зүйн нэг маргааны талаар санал зөрөлдөж, өөр өөр шийдвэр гаргах тохиолдолд Дээд сенат авч хэлэлцдэг. Холбооны захиргааны хэргийн шүүх нь хуульд заасны дагуу холбооны улс, муж хоорондын, мөн муж улсуудын өөр хоорондын маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.<sup>6</sup>

Хяналтын журмаар гомдлыг хуулийн дагуу дараахь хоёр тохиолдолд гаргана:

1. Захиргааны дээд шүүхээс гаргасан “магадлал”-ыг эсэргүүцсэн тохиолдолд

2. Захиргааны анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцсэн тохиолдолд шууд хяналтын шатны шүүхэд хандах. Давж заалдах шатыг алгасан захиргааны шүүхийн шийдвэрийг шууд хяналтын журмаар хянуулж болдог. үүнийг “алгассан хяналт” гэж нэрлэдэг. Энэ тохиолдолд нэхэмжлэгч ба хариуцагч зөвшөөрлөө бичгээр өгсөн байх ба захиргааны шүүхийн гаргасан шийдвэрт, эсхүл тусгайлан гаргасан тогтоолд хяналтын гомдол гаргах эрхийг заасан байх шаардлагатай. Ийнхүү хянуулах боломж нь тухайн хэрэг онцгой ач холбогдолтой эсхүл шүүхийн шийдвэр хэрэг хянан шийдвэрлэх суурь ажиллагаанд нийцээгүй тохиолдолд бий болдог./ХБНГУ-ын захиргааны шүүхийн тухай хуулийн 134.1/

Дээрх тохиолдлоос гадна мөн Захиргааны дээд шүүхийн шийдвэрт гомдол гаргасан бол хяналтын журмаар гаргасан гомдлыг тусгайлсан журмаар хүлээн авна. Гомдлыг Захиргааны дээд шүүхийн шийдвэрээр, эсхүл хяналтын журмаар гаргасан гомдлыг

<sup>6</sup> “Захиргааны хэргийн шүүх” цуврал гарын авлага №6, Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх. 2005. УБ., 9 дэх тал

хүлээн авахаас татгалзсаныг эсэргүүцэн гомдол гаргасан бол холбооны захиргааны шүүхийн шийдвэрээр хүлээн авдаг./ХБНГУ-ын захиргааны шүүхийн тухай хуулийн 132.1, 133/<sup>7</sup>

**Дүгнэлт:** Манай улсын ЗХХШТХ –д давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад тусгай ямар нэгэн урьчилсан нөхцөл шаардагдахгүй байхаар зохицуулсан байна. ЗХХШТХ –ийн 77 дугаар зүйлийн 77.3 –д нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эсэхээ сонгохоор зохицуулсан нь анхан шатны шүүхийн шийдвэрт шууд хяналтын журмаар гомдол гаргах эрхийг олгосон байна. Ингэж гомдол гаргахад гаргахад шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, мөн хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэдэг үндэслэлээс өөр босго буюу тусгай ямар нэгэн урьдчилан нөхцөл шаардагдахгүй байна. Энэхүү байдлаас болж нэхэмжлэгч болон хариуцагч тал хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдөх нөхцөл бүрдээд байна. Иймд ЗХХШТХ–ийн дээрх зүйлд заасан зохицуулалтыг “давж заалдах журмаар гомдол гаргаагүй этгээд хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй” гэдэг зохицуулалтаар өөрчлөх эсхүл кассацийн буюу алгассан хяналтын хэвээр үлдээн шууд хяналтын журмаар гомдол гаргах урьдчилсан нөхцөлийг өндөрсгөж, ямар нэг тусгай урьдчилсан нөхцөлүүдийг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хэрэв “давж заалдах журмаар гомдол гаргаагүй этгээд хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй” гэдэг зохицуулалтыг оруулахаар

<sup>7</sup> Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 2004. УБ., 232 дахь тал

болвол ЗХХШтХ –ийн 77 болон 81 дүгээр зүйлүүдийн холбогдох заалтуудыг өөрчлөх шаардлагатай юм.

ХБНГУ –ын доктор, профессор Филип Куниг Захиргааны болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн цаашдын хөгжлийн талаарх санал, зөвлөмждөө<sup>8</sup>: “Монголын захиргааны хэргийн шүүх 3 шатанд хуваагджээ. Анхан шатны араас давж заалдах болон хяналтын шатууд залгаж байна. Энэ хоёр хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай ямар нэгэн урьдчилан нөхцөл шаардагдахгүй бөгөөд арав хоногийн хугацаанд гомдол гаргах боломжтой. Давж заалдах болон хяналтын шатны хянан шийдвэрлэх ажиллагааны хянах хэмжээ, хүрээний талаар багахан зохицуулалт орсон байна. Энэ нь эрх зүйт төрийн үүднээс үндэслэл, тайлбар муутай санагдаж байна. Хэргийг бүхэлд нь шинээр хянан шийдвэрлэх эсэх буюу өмнөх шатанд хийгдсэн нотлох баримт үнэлгээнд баригдах эсэхийг тодорхой хэлж өгөөгүй байна. Шинээр нотлох баримт үнэлэх эсэхээ шүүх өөрөө шийдвэрлэх юм байна. Германы туршлагаас харахад хянан шийдвэрлэх ажиллагааны шатуудын ялгааг тодорхой болгож өгөх нь ач холбогдолтой юм биш үү гэсэн эргэлзээ төрж байна. Юуны өмнө давж заалдах болон хяналтын шатанд илүү өндөр босго хийж өгөх явдал юм. Германы эрх зүйн хөгжлийн сүүлийн жилүүдийг аваад үзвэл эрх зүйн хамгаалалтын боломжийг аль болох багасгах хандлагад чиглэсэн байсан юм. Гэхдээ энэ нь захиргааны аливаа шийдвэрт сэтгэл дундуур үлдсэн байсан иргэн бүр эрх зүйн хамгаалалтын бүх боломжийг бүрэн буюу хязгаарт нь тултал буруугаар хэтрүүлэн хэрэглэх боломжийг олгож байсан систем тогтсон байсантай холбоотой. Тийм учраас магадгүй анхан шатны шийдвэр нь хууль, эрх зүйн чанарын баталгааг хангаж чаддаггүй

<sup>8</sup> Монголын эрх зүйн шинэтгэл – 8 жил. Илтгэл болон зөвлөмжүүдийн эмхтгэл. 2003. УБ., 415 дахь тал

гэдэг үндэслэлээр эхлээд эрх зүйн хамгаалалтын өргөн боломжийг нээж өгөх нь зөв гэж үзэх байдал Монголд тогтож болохгүй” гэсэн байна.

Дээрх санал, зөвлөмжөөс харахад манай улсын ЗХХШТХ –д давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад өндөр босго буюу урьчилсан нөхцөл шаардагдахгүй байдаг учраас анхан шатны шүүхийн шийдвэрт бүгд л давж заалдах болон хяналтын шатны журмаар гомдол гаргадаг байдал практикт тогтоод байна.

**Ашигласан материал:**

- Монгол улсын үндсэн хууль – 1992 он
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль – 2002 он
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль–2002 он
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. УБ., 2009 он
- А.Эрдэнэцогт “Монгол улсын захиргааны процессын эрх зүй”. УБ., 2006 он
- П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги”. УБ., 2008 он
- Захиргааны хэргийн шүүх цуврал гарын авлага № 6: Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх. УБ., 2005 он
- Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. УБ., 2004 он
- Закон об административном суде германий. Verwaltungsgerichtsordnung (VwGO), Stand: 1995 Copyright: Deutsche Stiftung fur internationale und rechtliche Zusammenarbeit e. V. (IRZ), Bonn 1995

ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА



**Б.Болорсайхан**  
**МУИС, ХЗС-ийн магистрант**

**Түүхэн товчоон.** Түүхэн хугацааны явцад хүн төрөлхтөн шударга бус явдал, боолчлол, мөлжлөг, эрх мэдлээ урвуулан ашиглах, хүчтэй нь хүчгүйгээ дарамтлахын эсрэг бүхий л бололцоогоо ашиглан тэмцэж ирсэн билээ. Олон зуун жилийн тэртээ нийгэмд ёс суртахууны болон хууль ёсны дүрмийг бий болгож, хувь хүмүүс болон олон нийтийн хоорондын харилцааг зохицуулж ирсэн байна. Буддагийн сургааль, Коран, Библи бол дээрх ёс суртахууны хэм хэмжээний энгийн жишээ болно.

Жар гаруй жилийн өмнө байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын гол зорилго нь хүний эрх, хөгжил, энх тайван, ардчилал билээ. Гэхдээ хөгжил болон хүний эрх хэдэн арван жил тусдаа замаар явсан гэж болно. Ийнхүү салах шалтгаан бас бий. Барууны улс орнууд, ялангуяа Америкийн Нэгдсэн Улсад хүний эрхийг хөхиүлэн дэмжихдээ иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөөг эрхэмлэн авч үзсэнтэй холбогдуулан, хуульч, улс төрийн шинжлэх ухааны эрдэмтэд соронзон гүрт татагдах төмрийн үртэс мэт эдгээр орнууд уруу тэмүүлэх болсон ажээ. Нөгөө талаас авч үзвэл, хөгжлийг технологийн болон шинжлэх ухааны ололт амжилт, эдийн засгийн өсөлтөөр илэрхийлж байсан бөгөөд үүнд инженер, агрономич, эдийн засагчид чухал нөлөө үзүүлж байжээ. Хүйтэн дайны оргил үед буюу 1966 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүд хүний эрхийн хоёр тусдаа олон улсын гэрээг батлан



гаргасан нь Америкийн Нэгдсэн Улсын соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, социалист орнуудын дэмжлэгийг ихээр хүлээсэн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт юм.

Олон улсын хөгжлийг харьцуулан авч үзвэл, 1950 – 1960-аад он хүртэл эдийн засгийн хөгжлөөс нийгмийн хөгжил үрүү голчлон анхаарч, 1980 – 1990-ээд оны хооронд хүн төвтэй, зохистой хөгжлийн асуудалд анхаарах болжээ. Энэхүү өөрчлөлт нь нийгмийн асуудал, түүнд тохирсон шийдлийг олох, бодлогыг өөрчлөх, нийгмийн үйлчилгээнд төрөөс олгох төсвийг нэмэгдүүлэх, санаа бодлыг өөрчлөх компани т ажил зохион байгуулах, хөгжлийн төлөөх байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, үйл ажиллагааг үр нөлөөтэй болгосон байна.

Эдгээр өөрчлөлт ахар богино хугацаанд өргөн хүрээг хамрах болсон шалтгааныг олон улсын хөгжлийн байгууллага дэлхийг хамарсан ядуурлыг арилгах амлалтандаа хүрч чадаагүйтэй шууд холбоотой. Дэлхий тавин жилийн өмнөх үетэй харьцуулахад улс орнууд харьцангуй баян чинээлэг болсон боловч баян, хоосны ялгаа улам ихэсч, хүмүүс улам ядууралд өртсөөр байна.

Хүйтэн дайны төгсгөлд, хүний эрх болон хөгжлийг зэрэгцүүлэн авч үзэх болжээ. 1986 онд Нэгдсэн Үндэсний Байгууллага Хөгжих эрхийн тухай тунхаглалыг гаргажээ. Гэсэн хэдий ч баян чинээлэг Барууны орнуудын дэмжлэгийг хүлээгээгүй бөгөөд энэхүү тунхаглалд иргэний эрх, эдийн засгийн эрхийг хөгжилтэй холбож авч үзсэн нь шууд нөлөөлсөн байна. Гурван жилийн дараа буюу 1989 онд батлагдсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид хүний эрхийн мөн чанарыг дэлгэрэнгүй илэрхийлж, иргэний, улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын эрхүүдийн хоорондын уялдаа холбоог нотолсон байна.

## Эрхэд суурилсан хандлагын түүх

1940	НҮБ-ын Дүрэм: энх тайван, хүний эрх, хөгжил (1945) Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (1948)			
1950	ХҮЙТЭН ДАЙН		Эдийн засгийн хөгжил	
1960		Иргэний болон улс төрийн эрх	Эдийн засаг, нийгмийн эрх	
1970				Нийгмийн хөгжил Хүн төвтэй хөгжил
1980				
1990	Хөгжих эрхийн тухай тунхаглал (1986) Хүний эрхийн тухайн Венийн бага хурал: хүний эрх, хөгжил хамтдаа (1993) Копенгагены дээд хэмжээний уулзалт (1995) НҮБ-ын шинэчлэл: эрхэд суурилсан хөгжил (1997) Эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа, Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа (1998)			
2000	Амартъя Сен: Хөгжил эрх чөлөө болох нь НҮБХХ Хүний хөгжлийн илтгэл: Хүний эрх ба хүний хөгжил			

1993 онд Хүний эрхийн тухай Венийн бага хурлаар хүний эрхийн хуваагдашгүй байдал, хөгжлийг тодорхойлсон байна. Эдгээр өөрчлөлтүүдийн үр дүнд 1998 онд Нобелийн эдийн засгийн салбарын шагнал авсан, Энэтхэг гаралтай эдийн засагч Амартъя Сенийн бичсэн “Хөгжил эрх чөлөө болох нь” бүтээл, НҮБХХ-ийн Хүний хөгжлийн илтгэл гэсэн хүний хөгжил, хүний эрхийн тухай хоёр нөлөө бүхий бүтээл мянганы зааг дээр хэвлэгдэж, олон нийтийн хүртээл болжээ.

Одоо НҮБ-ын харьяа байгууллагууд (UN, UNDP, UNICEF, UNFPA, UNIFEM, UNAIDS, WHO гэх мэт), Барууны орнуудын засгийн газар (Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс, Швед, Голланд, Австрали, Норвеги гэх мэт), төрийн бус байгууллагууд (ActionAid, Oxfam, Save the Children, CARE гэх мэт) эрхэд суурилсан хандлагыг дэмжин хэрэглэж байна.<sup>1</sup> Энэхүү хандлагыг улам ихээр ашиглах болсон нэг шалтгаан бол хүний эрх

болон хөгжил үрүү дангаар бус, хамтад нь зорьсон нь илүү үр дүнтэй байгаатай шууд холбоотой.

Хүний эрх нь олон улсын хэм хэмжээнд заавал биелэгдэх шинжтэй хууль тогтоомжид тусгагдан, эх сурвалж болсноор шударга ёс, тэгш байдал, оролцоо, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжих боломж олгодог. Гэхдээ эдгээр стандартыг нийцүүлэн өөрчлөх нь олон улсын гэрээг соёрхон батлахаас маш хэцүү билээ. Хүний эрхийг хүндэтгэснээр ардчилал, хүний хөгжих боломжийг нэмэгдүүлдэг. Дэлхийн банк, Олон улсын валютын сан, НҮБ, олон улсын хандивлагчид зэрэг хөгжлийн байгууллагууд хүний эрхийг баталгаажуулахын тулд их хэмжээний хөрөнгө, нөлөөллийн хүчтэй арга хэрэгслийг ашигласаар байна.

Хүний эрхэд суурилсан хандлагыг бүрдүүлэгч өөр нэг хэсэг бол хүмүүст эрх олгох, идэвхтэй хөдөлгөөнд оруулах, өөрийн эрх, эрх чөлөөг шаардах явдлыг дэмжих болно. Ийнхүү хүний эрх, хөгжил, нийгмийн идэвхтэй хөдөлгөөн нь дэлхий дахинд тархсан ядуурал, мөлжлөг, дарамт, шударга бус явдлыг арилгах найдварыг төрүүлж байна.

Эрхэд суурилсан хөгжлийн хандлага нь шударга ёс, тэгш байдал, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, ядуурал, мөлжлөгийн үндэс болсон ноцтой асуудлуудыг шийдэхийг зорьдог. Үүний тулд эрхэд

---

<sup>1</sup> Одоо болтол АНУ-ын Засгийн газрын зүгээс хөгжлийг зорилт олгосон хүний эрхэд суурилсан хандлагыг дэмжих явдал бага байгааг эдийн засаг, нийгмийн эрхийн үзэл санааг өөрчлөх, хүний эрхийг тайлбарлахад иргэний, улс төрийн эрхээр л тайлбарлах, ядуу улсыг хөгжүүлэх гэсэн оролдлого бүтэлгүйтэх зэргээр хандлагаа өөрчлөхгүй байгаатай холбож тайлбарлаж болно. Мөн АНУ нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийн эсрэг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенцид соёрхон батлаагүй болно.

суурилсан хандлага нь хүний эрхийн стандарт, зарчим, арга, нийгмийн идэвхтэй оролцоо, хөгжлийг удирдлага болгодог билээ.

Нөгөө талаас хөгжил бол хөрөнгийг хуваарилах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, ядуурлыг бууруулах, орлого нэмэгдүүлэхэд голчлон анхаардаг. Нийгэм болон улс төрийн идэвхтэй оролцооны үр дүнд хүмүүс эрх мэдлийг дахин хуваарилахыг шаардаж эхэлдэг. Жишээлбэл, баян, ядуу орнуудын хооронд зээлийн журмаар хөрөнгийг хуваарилах, эсвэл худалдааны дүрмийг өөрчлөх, эмэгтэйчүүд тохирсон ажилд таарсан цалин авах, ажилчид шударгаар цалин, хөлсөө тооцуулах, эсвэл газаргүй тариачин тариалангийн газрыг дахин хуваарилахыг шаарддаг.

**Хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн олон улсын гэрээ**

1948 он Хүний эрхийн түгээмэл тунхаглал  
1949 он Женевийн конвенци  
1965 он Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц  
1966 он Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт  
1966 он Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт  
1979 он Эмэгтэйчүүдийн эсрэг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц  
1984 он Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци  
1989 он Хүүхдийн эрхийн тухай конвенц  
2003 он Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц

Тэгвэл хүний эрхийг олон улсууд хүлээн зөвшөөрсөн хуулийн болон ёс суртахууны стандартад буюу жишигт дээдлэн тусгасан ажээ. Доорх түгээмэл, хүлээн зөвшөөрсөн жишгүүд нь хэвшсэн хөгжлийн онол, практикт маш ихээр дутагдаж байна. Тодруулбал:

**Хүний эрх бол түгээмэл шинжтэй.** Хүний эрхийн гэрээнүүд нь цаг ямагт, дэлхийн аль ч өнцөгт байгаа бүх хүн төрөлхтний үндсэн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрх, эрх чөлөөг бэхжүүлж өгдөг. Тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх, бол хүний суурь эрх болдог.

**Хүний эрх бол салшгүй шинжтэй.** Бүх хүн төрсөн цагаас эхлэн адил эрх эдэлнэ. Хүний эрхийг үл тоомсорлох, орхигдуулж болохгүй.<sup>2</sup>

**Хүний эрх нь үүрэг, хариуцлагатай нягт холбоотой.** Хүний эрхийн тухай ойлголтын төвд эрх эдлэгч болон үүрэг хүлээгчийн хоорондын харилцааг чухалчлан үздэг. Төр болон бусад “үүрэг хүлээгч” нар бүх хүмүүсийн эрхийг тэнцүү хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үүрэг хүлээдэг. Энэ нь төр бүх зүйлийг хангана гэсэн үг биш бөгөөд төр нь эцэг эх, хувийн хэвшил, орон нутгийн байгууллага, хандивлагч болон олон улсын байгууллага зэрэг бусад үүрэг хүлээгчид боломж олгосон нөхцлийг бий болгох үүрэг хүлээдэг. Эрх эдлэгч нарын хувьд бусад эрх эдлэгчдийн эрхийг хүндэтгэж, зөрчихгүй байх үүрэгтэй.

---

<sup>2</sup> Энэ зарчимд хамаарахгүй хэдэн зүйл бий. Шоронгийн хоригдлын шилжин явах эрх чөлөөг үгүйсгэдэг. Онц байдлын үед үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг тодорхой хугацаанд түр хязгаарладаг. Гэхдээ хязгаарлалтыг буруугаар ашиглах, амьд явах эрх, эрүү шүүлтээс хамгаалагдах эрх зэрэг бусад эрхийг хэзээ ч хязгааралж болохгүй.

**Төр хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг хүлээнэ.**

**Эрхийг хүндэтгэх** нь төрийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа хүний эрхийг зөрчиж болохгүй гэсэн үг. Төр нь эрүүдэн шүүх, дур зоргоор баривчлах, хууль бусаар хүчээр эд хөрөнгийг хураах, эрүүл мэндийн үйлчилгээг ядуу хүмүүст хүргэхгүй байх зэргээр хүмүүсийн эрхийг зөрчихөөс ямагт зайлсхийх хэрэгтэй.

**Эрхийг хамгаалах** нь төр бусад этгээдийн зүгээс хүний эрхийг зөрчих явдлыг арилгах, учирсан хохирлыг тохиромжтой, боломжит хэлбэрээр нөхөн төлүүлэхийг хэлнэ. Жишээлбэл, ажил олгогчид хөдөлмөрийн дотоод журмыг гаргаж, сахин биелүүлэх, мэдээллийн хэрэгслийн монополийг байдлыг арилгах, хүүхдээ сургуулиас завсардуулсан эцэг эхэд ойлгуулах зэрэг үйлдлийг хэлж болно.

**Эрхийг хангах** нь эрхийг бодитойгоор ойлгож, эдлэхэд нөлөөлөх бүхий л эерэг арга хэмжээг авахыг хэлнэ. Жишээлбэл, эрхэлсэн ажил хөдөлмөрт тохирсон хөлс авах зохицуулалтыг хуулинд тусгах, ядуу эмзэг бүлэг ихээр орших бүс нутагт төсвийг харьцангуй ихээр хуваарилах гэх мэт.

Олон улсын хандивлагч нарын хувьд, бүх хүүхэд үнэ төлбөргүй, заавал боловсрол эзэмших ёстой зэрэг олон улсын хүний эрхийн стандартыг хөхиүлэн дэмжиж, түүнд суурилсан нийгэм, эдийн засгийн бодлогыг баталгаажуулж, мөн эрүүл мэнд, боловсролын хөтөлбөрт хангалттай хөрөнгийг хуваарилах шаардлагатай болдог. Гэхдээ ядуу буурай орны нийгмийн үндсэн үйлчилгээний нөхцлийг өөрчлөх, өр төлбөр төлөх, эдийн засгийн

өөрчлөлт хийхийг хүчээр албадах зэрэг болзолгүйгээр бүх хүүхдэд боловсрол олгохоор хөрөнгийг хуваарилах ёстой. Үүнээс гадна ядуу буурай орныг хөгжилтэй, баян орны зах зээлд гарахад саад болох худалдааны хориг, хөдөө аж ахуйн хураамжийг арилгах үүрэгтэй.

**Оролцоо бол хүний үндсэн эрх болохын хувьд** бүх хүүхэд, эмэгтэйчүүд, эрчүүд өөрийн эрхийг үүрэг хүлээгч нараас шаардах ёстой. Мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх иргэний эрхүүдээр дамжуулан, хүмүүс эрхээ идэвхтэй байдлаар шаардах боломжтой.

**Хүний эрх бол салшгүй, харилцан уялдаатай.** Хүний эрхэд иргэний, улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын хүрээний бүх эрх багтана. Тодорхой нэг эрхийг үгүйсгэснээр өөр нэг эрхэд шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Жишээлбэл, засгийн газар тахлын огцом тархалтын талаар мэдээллийг нууцалсан тохиолдолд хүмүүс өөрсдийгөө тахлаас хамгаалж чадахгүй бөгөөд тэдгээрийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх зөрчигдөж эхэлнэ. Гэхдээ төр эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд халдсан гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах арга хэмжээ авах боломжгүй.

Хүний эрхэд суурилсан хандлагын хүрээнд “эрх эдлэгч”, “үүрэг хүлээгч” гэсэн ойлголт байнга яригддаг. Эрх эдлэгчээр эрэгтэй, эмэгтэй эсвэл хүүхэд, арьс өнгө, угсаатны бүлэг, нийгмийн нөхцлөөс үл хамааран, дэлхий дээр амьдрагч 6,774,078,703 хувь хүнийг илэрхийлдэг бол үүрэг хүлээгчээр ихэвчлэн тухайн улсын төр, зарим тохиолдолд тусгай үүрэг бүхий хувь хүнийг илэрхийлдэг ажээ.

Эрхийг ойлгож, эдлэхэд өөрчлөлт хэрэгтэй бөгөөд хүний эрхийг эдлүүлэхэд олон улсын гэрээг соёрхон батлахаас илүү зүйлс хийхийг шаарддаг. Төр болон үүрэг хүлээгч нар:

- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр өөрчлөх
- Эрхийг дэмжсэн эдийн засгийн бодлого боловсруулах
- Эрхийн зөрчлийн эсрэг үр нөлөөтэй хуулийн хариуцлагын тогтолцоог баталгаажуулах
- Ядуу, эмзэг бүлгүүдэд төсөв, хөрөнгийг харьцангуй ихээр хуваарилах
- Ухамсар, санаа бодол, төрх байдал, туршлага, хэм хэмжээг өөрчлөх
- Байгууллага, үйлчилгээний чанар, ач холбогдол, хурдан шуурхай байдлыг нэмэгдүүлэх
- Шийдвэр гаргах, өөрсдийн эрхээ шаардахад эрх эдлэгч нарын оролцоог улам нэмэгдүүлэх бололцоог бий болгох
- Хүмүүсийн талаарх мэдээллийг сайтар цуглуулж, тэдний эрхийг хангах үйл ажиллагаанд мониторинг буюу хяналт–шинжилгээ хийх шаардлагатай:

**Эрхэд суурилсан хандлага болон эрх эдлэгч, үүрэг хүлээгч нарын хоорондын харилцаа**





Хүний эрхэд суурилсан хандлага нь ядуу оронд ямагт хязгаарлагдсан байдаг эрхийг хангах бололцоо, боломжийг тодорхойлдог. “Дэвшилт бүхий бодит биелэлт” нь улс орнууд хөрөнгө, бололцоондоо тулгуурлан, хүний эрхийг ойлгож, эдлэснээр хөгжилд хүрэх боломжтой гэсэн санааг агуулдаг. Гэхдээ энэхүү зарчмыг буруугаар ойлгож болохгүй. Төр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрх, эрүү шүүлтээс хамгаалагдах эрхийг зөрчсөний төлөө уучлал эрэх нь ховор бөгөөд эрүүл мэнд, боловсролын салбарт хэдий хэмжээний хөрөнгө зарцуулах, батлан хамгаалах салбарт хэдий хэмжээний хөрөнгө зарцуулахыг ямагт өөрсдөө шийддэгийг анхаарах хэрэгтэй.

Эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа нь хүмүүс болон байгууллагууд эрх мэдлээс үл хамааран, эрхийг хангах үүрэг хүлээх ёстой гэж үздэг. Ийнхүү эрх эдлэгч нарыг эрхээ шаардах, нийгэмд улс төр, эдийн засаг, нийгмийн холбогдолтой шийдвэр гаргахад оролцох явдлыг дэмждэг байна. Эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа нь дэмжлэг авах нөлөөг нэмэгдүүлэх, сайжруулах, бодлого, туршлагыг өөрчлөх, тодорхой нийтлэг зорилтын төлөө хамтран ажиллах, эрх мэдлийн харьцааг өөрчлөхийг зорьдог.

Хөтөлбөр боловсруулах эрхэд суурилсан хандлагыг тодорхойлохын тулд дараах зүйлсийг шаарддаг. Үүнд:

- Хүмүүс, тэдгээрийн эрхэд шууд чиглэсэн удаан хугацааны зорилтыг агуулах ба орон нутгийн, үндэсний, олон улсын түвшин дэх аливаа асуудал, шалтгаан, хариуцлагыг задлан шинжлэх
- Нийтлэг эрхэд суурилсан зорилтод хүрэхийн төлөө төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах
- Хүний эрхийн ноцтой зөрчилд анхаарлаа хандуулж, нэн ялангуяа хүнд нөхцөлд буй бүлэг хүмүүсийг тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхахгүй байх

· Бүх түвшинд хүний эрхийн үүрэг хүлээгч нарын хариуцлагатай байдлыг сайжруулах. Хууль тогтоомж, бодлогыг өөрчлөх, төсөв хуваарилах, байгууллагын дүрэм, туршлагыг өөрчлөх, санаа бодол, төрх байдлыг өөрчлөх зэрэг холбоо хамаарал бүхий шууд чиглэсэн арга хэмжээ авах

· Эрх эдлэгч (хүүхэд, эмэгтэйчүүд, иргэний нийгмийн байгууллага) нарын эрхээ шаардах оролцоог дэмжих

**Эрхэд суурилсан зорилт нь** тодорхой бүлэгт чиглэсэн, цаг хугацаа заасан зорилтоос ялгаатайгаас гадна шууд 100 хувь хүний эрхийг ойлгуулах, эдлүүлэхэд чиглэдэг онцлогтой (“Боловсролыг бүх хүнд” зэрэг зорилтыг жишээлж болно). Бүх хүн эрхээ эдэлдэг болсон үед л эрхэд суурилсан зорилтонд хүрсэнд тооцно гэж үздэг. Иймээс олон төрлийн байгууллагын үйл ажиллагаанд анхаарал хандуулдаг билээ. Энэхүү зорилтгүйгээр хөтөлбөрөөр дамжуулан, хүний эрхийг ойлгуулах баталгаа бүрдэхгүй гэсэн үг. Байгууллагын хувьд, бусад хүмүүсийн үйлдлээр тодорхой эрхийг ойлгуулахын тулд юу хийх шаардлагатай, ямар боломж бололцоо, чадвар шаардлагатайг тусгайлан тогтоосон байх хэрэгтэй.

**Нийтлэг зорилтын төлөө хамтран ажиллах нь.** Эрхэд суурилсан зорилт нь хүний эрхийг бодитойгоор хэрэгжүүлэх явдалтай шууд холбоотой. Гэхдээ нэг байгууллага өөрийн хүрээнд юу хийх боломжтойг анхаарна гэсэн үг биш. өргөн хүрээг хамарсан, маш их хичээл зүтгэл шаардсан, урт хугацааны зорилт болсон эрхэд суурилсан зорилтод хүрэхийн тулд бүх төрлийн түвшинд төрөл бүрийн байгууллагатай харилцаа холбоо тогтоож, олон төрлийн хандлагыг хэрэглэдэг болно. өөрөөр хэлбэл, хамтарсан задлан шинжилгээ хийж, нийтлэг стратегийн дагуу үйл ажиллагаа явуулж, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахыг хэлнэ. Иймээс эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагааны хувьд,

байгууллагууд цаашид нэг нэгнээс тусгаар үйл ажиллагаа явуулах боломжгүй.

**Хүний эрхийн ноцтой зөрчил, хүнд нөхцөлд байгаа хүмүүст анхаарлаа хандуулах нь** эрхэд суурилсан хандлагын үндсэн хэсэг болно. Хөгжлийн хөтөлбөрүүд байнга хязгаарлагдмал нөөцийн хүрээнд хамгийн олон тооны хүмүүсийг хамруулахыг хичээдэг боловч хүрэхэд хэцүү, хол байрладаг хүмүүсийг хамруулахгүй орхидог билээ. Харин эрхэд суурилсан хандлагаар тухайн бүлэг хүмүүсийг тодорхойлон, тэдгээрийн эрхийг баталгаажуулдаг ажээ. Гэхдээ эрхэд суурилсан хандлагыг нийгмийн хүнд нөхцөлд байгаа хүмүүсийг л зөвхөн анхаардаг гэж үзвэл өрөөсгөл ойлголт болно.

Хариуцлага ба оролцооны тухайд эрхэд суурилсан хөгжлийн гол үүрэг нь холбогдох үүрэг хүлээгч нарыг тодорхойлж, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан, ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийн эдлэх эрхийг ойлгуулах зорилгоор хүний эрхийг хангахад чиглэдэг. Зөвхөн шууд үүргийг тайлбарлаж, хүний эрхийг хангахад хүмүүст тусласнаар үүрэг хүлээгч нарын хариуцлагыг сайжруулах боломжгүй. Мөн эрхээ шаардах хүмүүсийн чадварыг нэмэгдүүлж чадахгүй. Үүнтэй холбогдуулан, төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд үүрэг хүлээгч нарын хариуцлагыг нэмэгдүүлж, хүмүүсийн чадавхижуулах боломжтой.

**Эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаанд хэрэглэдэг арга:**

- Бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, төсөв хуваарилалтыг өөрчлөхөөр шийдвэр гаргагчид шахалт үзүүлэх
- Бодлого, төсвийн хуваарилалтад өөрчлөлт оруулахыг шаардуулахаар хүмүүсийг идэвхжүүлэх

- Эрх мэдлээ урвуулан ашигласан, эрхийн зөрчлийн тухай илтгэх, олон нийтийн анхаарлыг хандуулахаар нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах

- Стандарт, дүрэм, журмыг тогтоож, хянан шалгах. Тухайн хэм хэмжээг мөрдөхөөр эрх зүйн зохицуулалтын тогтолцоог бий болгох

- Төрийн үйлчилгээний чанарт санхүүгийн шалгалт хийх

- Хүний эрхийн зөрчлийг хянан шалгаж, илтгэх

- Хүний эрхийн хяналтын байгууллага байгуулан, чиг үүргийг дэмжих

- Олон нийт болон шийдвэр гаргагчдын хүний эрхийн мэдлэгийг нэмэгдүүлэх

- Хүний эрхийг хангаж, шударга ёс, тэгш байдлыг тогтооход шүүхийг ашиглах

Эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа нь хүмүүс, тэдгээрийн эрхэд тодорхой, тохиромжтой үр дүн үзүүлэх өргөн хүрээний аргыг хэрэглэх бөгөөд энэхүү хандлагыг үүрэг хүлээгч нар үүргээ биелүүлэх, хүмүүс эрхээ шаардах, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, тэгш байдлыг хангахад ашигладаг. Зохистой арга хэмжээг сонгоход тухайн улс орны боломж, холбогдох эрх, анхаарал тавих асуудал, байгууллагын бүрэн эрх, бололцоог харгалздаг.

Жишээлбэл, Вьетнам Улсад хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэхийн тулд хууль тогтоомжийг өөрчлөхгүйгээр бэлгийн мөлжлөгийн тухай олон нийтийн мэдлэгийг мэдээллийн хэрэгсэл ашиглан нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын арга хэрэгслийн талаар нийгмийн ажилтан, хуулийн байгууллагын алба хаагчийг бэлтгэж, сургуулийн, асрамжийн газрын, ажил эрхлэгч зэрэг хүүхдүүдийн үгийг сонсох механизмыг бий болгосон байна.

Камбож Улсад ажилладаг нэгэн байгууллага ядуурлыг бууруулахын тулд анхан шатны нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, өөрийн өмчийн газаргүй нутгийн иргэд газар өмчлөх эрхээ шаардах, Камбож Улсын Засгийн газрыг гадаад улсын худалдааны хоригыг цуцлах арга хэмжээ авахад нөлөөлөх, үндэсний барааг зах зээлд нийлүүлэхийг шаардсан байна.

### **Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа**

Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа бол Хүүхдийг ивээх сан – олон улсын байгууллагын эрхэд суурилсан хандлагын нэг хувилбар бөгөөд хүүхэд, тэдгээрийн эдлэх эрхэд анхаардаг ажээ. Агуулагдах хэсгийг авч үзвэл, ерөнхийдөө эрхэд суурилсан хандлага болон хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагааны хооронд ялгаа нэн ховор. Гэхдээ хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагааны гол онцлог бол хүүхэд болон насанд хүрсэн хүний хоорондын ялгаанд тулгуурласан болно.

Тодруулбал хүүхэд бол хүн төрөлхтний хамгийн эмзэг бүлэг билээ. Хүүхдийн насны хүрээг 0 – 18 насаар тодорхойлсноос гадна нас, чадвар, хөгжлийн түвшингээр бусад хүмүүсээс ихээхэн ялгагддаг. Иймээс Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа нь хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, чадвар, бүрэн эрхэд анхаарлаа хандуулдаг байна.

Хүний эрхийн бүх олон улсын гэрээ хүүхдэд нэгэн адил үйлчилдэг. үүнээс гадна тэдгээрт тусгайлан Хүүхдийн эрхийн тухай конвенцийг батлан гаргасан ажээ. Энэхүү конвенц нь хүүхдийн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын эрхийг

баталгаажуулж өгсөн байна. Мөн хүүхдийн эрхийг тусгай хамгаалалтаар тодорхойлжээ.

Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаа нь богино болон урт хугацааны турш хүүхдийн дээд ашиг сонирхолд тулгуурладаг бөгөөд хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргахад хүүхдийн ашиг сонирхол, хүслийг байнга тусгах, хүүхдийн амьдрал, хөгжил, хамгаалалттай холбоотой урт хугацааны шийдвэрт хүүхдүүдийг сайн дураар оролцуулахыг эрхэмлэдэг.

Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаанд хүүхдийг гэр бүлийн хүрээнээс илүү өргөн хүрээнд авч үздэг байна.

#### **Хүүхэд бол нийгмийн нэг хэсэг мөн.**



Дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүүхэд бүр тэд нараас хол газарт шийдвэр гаргасан бодлого, төсвийн нөлөөн дор амьдарч байдаг. Хүүхдийн эрхийн байгууллагууд эдийн засгийн бодлого хүүхэдэд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт – шинжилгээ, задлан шинжилгээ хийх, хүүхдийн эрхийг баталгаажуулах, бодлого гаргагч нарт нөлөөлөх үүрэг хүлээдэг.

Хүүхэд бол гэр бүл, сургууль, олон нийт, нийгэмд идэвхтэй оролцох, мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх,

шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, эвлэлдэн нэгдэх эрхтэй байдаг. Төрсөн цагаас эхлэн, хүүхэд өөрийгөө илэрхийлэх боломжтой. өсөж томрохын хэрээр нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох, шийдвэр гаргахад нөлөөлөх боломж ихэсдэг. Хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагаанд хүүхдийн нийгэм, эдийн засгийн хувь нэмрийг онцгойлон авч үздэг бөгөөд гэр бүл, сургууль, олон нийт, нийгэм зэрэг хүүхдэд нөлөөлөгч бүх орчин болон хүүхэдтэй холбоотой бүх асуудалд хүүхдийн оролцоог дэмжиж ажилладаг. Асран хүмүүжүүлэх, зааж сургах аргыг тодорхойлон, хүүхдийн өөрийгөө илэрхийлэх, шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлэхийн төлөө төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж байна. Мөн бодлого тодорхойлох, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт – шинжилгээ хийх, үнэлэхэд хүүхдийг оролцуулах, удирдлагын хэсэгт хүүхдийн оролцоог хангадаг билээ.

Хүүхдүүд бол эрх эдлэгч нар болдог боловч хүүхдийн өөрсдийн эрхийг шаардах чадварыг хязгаарлах хэд хэдэн хүчин зүйлс бий. Учир нь хүүхэд байнга хүүхдээрээ байдаггүй. Хуулинд зааснаар хүүхэд 18 нас хүрснээр насанд хүрсэн хүн болдог. Хүүхэд нь насанд хүрсэн хүнтэй ижил эрх эдэлдэг боловч сонгох, сонгогдох эрх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрх, хуулийн этгээд байгуулах эрх, гэрээнд гарын үсэг зурах эрхийг насанд хүрсэн хүнтэй харьцуулахад тодорхой хэмжээгээр хязгаарладаг.

Иймээс насанд хүрсэн хүмүүс хүүхдийн эрхийг хамгаалах, шаардах үүрэг хүлээдэг. Эцэг эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчид бол хүүхдэд хамгийн ойр орших үүрэг хүлээгч нар билээ. Эрхэд суурилсан хандлага нь хүүхэд, насанд хүрсэн хүмүүс ажиллах байгууллагыг хүүхдийн эрх, эрх чөлөөг шаардахад дэмжлэг үзүүлдэг.

**Хүний эрхэд суурилсан хандлага, хүүхдийн эрхэд суурилсан хөтөлбөр боловсруулах ажиллагааны арга замыг тодорхойлох замаар дүгнэлт хийвэл:**

**ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

**Хариуцлагатай байдал:**

- үүрэг хүлээгч хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг хүлээх
- үүрэг хүлээгч нарын үүргээ биелүүлэх боломж, хариуцлагыг нэмэгдүүлэх
- Хариуцлагын тогтолцоо, бэрхшээлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх

**Оролцоо:**

- Эрх эдлэгч нар эрхээ шаардах
- Хүмүүсийг эрхээ шаардахад дэмжлэг үзүүлэх
- Эрх шаардагч идэвхтэй байгууллагын бололцоог нэмэгдүүлэх
- Хүмүүсийн эрхээ шаардах улс төрийн хэмжээг өргөжүүлэн ихэсгэх

**Тэгш байдал:**

- Нийгэм дэх хүүхдийн бүхий л оролцоог хөхиүлэн дэмжих
- Тэгш байдал, ялгаатай байдал, хувийн онцлог, сонголт хийх бололцоог дэмжих
- Ялгаварлан гадуурхалттай тэмцэх

**ЧИГЛЭЛ:**

**Хууль тогтоомж:**

- Хууль тогтоомжийг өөрчлөх, ялгаварлан гадуурхаагүй хууль, тэгш байдал, оролцоог хангасан хуулийг хамгаалах
- Хуулийн байгууллагын ялгаварлан гадуурхалт, үл тоох явдлыг арилгах



**Бодлого, хөтөлбөр:**

- Тэгш байдал, ялгаатай байдал, хувийн онцлог, сонголт хийх бололцоог дэмжих зорилгоор бодлого, хөтөлбөрийг өөрчлөх
- Ялгаварлан гадуурхалтаас үр нөлөөтэй хамгаалах бодлогыг дэмжих
- Бодлого, хөтөлбөрийн өөрчлөлт зайлшгүй шаардлагатайг ухуулан үнэмшүүлэх (лобби)

**Эдийн засаг:**

- Хүний эрхэд суурилсан эдийн засгийн бодлогыг удирдлага болгосон хүний эрхийг хангасан эдийн засгийн орчныг хөхиүлэн дэмжих (дэвшилтэт татварын тогтолцоо, шударга наймаа, хөдөлмөрийн стандартыг даган мөрдөх, нийгмийн үндсэн үйлчилгээг баталгаатай хүргэх гэх мэт)

**Төсөв, хөрөнгө:**

- Олон улсын, үндэсний, бүс нутгийн, тойргийн, орон байрны түвшинд хүүхдэд хуваарилах төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэхээр ухуулан үнэмшүүлэх
- Хөрөнгийг тэгшээр хуваарилахаар ухуулан үнэмшүүлэх

**Үйлчилгээний чанар, төрийн байгууллагын бүтэц, механизм, журам:**

- Байгууллагын чанар, чадварыг нэмэгдүүлэх
- үүрэг хүлээгчийн эрх зүйн зохицуулалтыг боловсруулах (төсөл, хөтөлбөр, бодлогын бүх түвшинд зохицуулалтыг бий болгох)
- Байгууллагын болон бүтцийн бэрхшээлийг арилгах, хариуцлагатай байдлыг бий болгох
- Бэрхшээлийг арилгаж, нийгмийн бүх түвшин, байгууллагын бүх хэсгийн шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх

· Бүх хүүхдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, хамаарал, зохистой байдлыг сайжруулах, бэрхшээлийг арилгах

**Мэдээлэл:**

· Мэдээлэл цуглуулах, эрхийн зөрчлийн тодорхойлохоор эрхүүдэд хяналт – шинжилгээ хийх (хүний эрхийг задлан шинжлэх, илтгэх)

· Эрх эдлэгч нарт мэдээллийг нээлттэй болгохоор засгийн газрын байгууллагад нөлөөллийн арга хэмжээ авах (ил тод байдал)

· Мэдээллийн тогтолцоо, мэдээлэл түгээх тогтолцоог сайжруулах

· Хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулах, бүлэглэн ангилах. Хүүхдийн мэдээллийг нас, хүйс, чадвар (хөгжлийн бэрхшээл), угсаа гарвалаар бүлэглэж, хоорондын ялгааг задлан шинжлэх, судлах

**Төрх байдал, хэм хэмжээ, санаа бодол, туршлага:**

· Нийгмийн бүх хэсэгт буюу нийгэм, олон нийт, гэр бүлийн хүрээнд, шийдвэр гаргагч нарын дунд, байгууллагын хэм хэмжээ, үнэт зүйл, санаа бодол, төрх байдал, туршлагад эрхэд суурилсан өөрчлөлт хийж, эрхийг баталгаажуулах

· Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдгээрийн анхаарал, санаа бодол, туршлагыг өөрчлөхөөр компанит ажил зохион байгуулах

· Хүүхдийг мөлжлөг, дарамтаас хамгаалах

· Ялгаварлан гадуурхалттай тэмцэх

· Ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хэрэгцээ, нөхцөл байдлыг нийгэмд (байгууллагад) мэдүүлэхээр нийтийн анхаарлыг хандуулах

· Гэр бүл, олон нийт, байгууллага, нийгмийг улам ил тод, улам чөлөөтэй байдлыг бүрдүүлэх

**Эрхээ шаардахад оролцох:**

- Хүүхэд, насанд хүрэгчдийн хоорондын эрх мэдлийн харилцааг өөрчлөхөөр насанд хүрэгчид болон хүүхэдтэй хамтран ажиллах
- Хүүхэд, насанд хүрэгчийн оролцооны чадварыг нэмэгдүүлэх, анхаарлыг хандуулах
- Төсөл, хөтөлбөр, байгууллага, бодлого, хууль тогтоомж, гэр бүл, сургууль, олон нийтийн дунд хүүхдийн мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг иргэний эрхийг хөхиүлэн дэмжих
- Бэрхшээлийг арилгаж, нийгмийн бүх түвшин, байгууллагын бүх хэсгийн шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхэд, насанд хүрэгчид эрхээ шаардахад дэмжлэг үзүүлэх, иргэний эрхийг таниулан ойлгуулах
- Хүмүүс болон байгууллагын өөрсдийн эрхийг шаардах бололцоог хангах
- Тодорхой бүлэг хүмүүсийн өөрийн эрхийг шаардахад дэмжлэг үзүүлэх
- Хүүхдийг ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, нийгэмд идэвхтэйгээр оролцох бололцоог хангах



**Ашигласан эх сурвалж:**

- Хүний эрх, НҮБ-ын ажилтнуудад зориулсан гарын авлага УБ, 2003 он
  - [www.universalhumanrightsindex.org](http://www.universalhumanrightsindex.org)
  - [www.mn-nhrc.org/olon\\_ulsiiin\\_geree](http://www.mn-nhrc.org/olon_ulsiiin_geree)
  - Sen, Amartya (1999) *Development as Freedom*. Alfred A Knopf, New York, ISBN 0375406190
  - UNDP (2000) *Human Development Report 2000: Human Rights and Human Development*. Oxford University Press, New York, ISBN 0-19-521678-4.
  - The World Factbook 2007-2008, CIA.
  - Eyben, Rosalind (2003) *The Rise of Rights: Rights-Based Approaches to International Development*. IDS Policy Briefing, Issue 17. IDS, Sussex, UK. [www.ids.ac.uk](http://www.ids.ac.uk)
  - Save the Children (2002) *Child Rights Programming. How to Apply Rights-Based Approaches in Programming. A Handbook for International Save the Children Alliance Members*. International. Save the Children Alliance, London, ISBN: 91-7321-038-2.

## ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН НЭР ТОМЪЁО

**A Contrario (Argument/Point of View/ Proposition) [Latin, lit: from the opposite/contrary]**

**A Contrario (үндэслэл/үзэл бодол/Санал) [Латин: эсрэг талаас]**

Аливаа асуудлаар эсрэг талаас үзэл бодол, саналаа илэрхийлэх, үндэслэл гаргах гэсэн утгатай латин үг. Нэг этгээд “С”-г зөв гэж батлахад нөгөө этгээд “С”-г буруу хэмээн сөрөг байр сууринаас эсрэг үндэслэл гаргах. Ихэнх тохиолдолд A Contrario гэж хэрэглэх боловч заримдаа өгүүлбэрийн эхэнд дан Contrario гэж хэрэглэгдэх тохиолдол бий.

**Actio Popularis (Complaint) [Latin, lit: law suit of the people]**

**Actio Popularis (Гомдол) [Латин: ард түмний нэхэмжлэл]**

Европын хүний эрхийн конвенцид заасан гишүүн улсын зүгээс гаргаж болзошгүй аливаа хүний эрхийн зөрчлийг урьдчилан харж, дагаж мөрдөж эхлээгүй хууль, дүрэмд бичгээр

гомдол гаргахыг ийнхүү латинаар нэрлэдэг.

Энэ нь олон түмний нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах ажиллагаатай адил утгатай. Гомдлыг тухайн хуулийг хэрэгжүүлэхэд өртөж болзошгүй бүх хүмүүсийн нэрийн өмнөөс гаргасан тохиолдолд энэ нэр томъёог хэрэглэдэг.

Комисс буюу шүүхээр уг гомдлыг хүлээн авах эсэхийг хэлэлцэхэд гомдол гаргагч нь уг зөрчлийн хохирогч мөн эсэхийг тогтоодог. Олон түмний нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргасан гомдлыг шүүхэд хэлэлцэхийг гол төлөв татгалздаг. Европын хүний эрхийн конвенцид багтдаг улс орнуудад энэ нь шүүхэд хэлэлцэхийг татгалзах нөхцөл болдог байна.

**Actus Reus (Criminal Law) [Latin, lit: guilty act]**

**Actio Popularis (Эрүүгийн эрх зүй) [Латин: буруутай үйлдэл]**

Эрүүгийн хариуцлага хүлээж, шийтгэл хүлээх нөхцөл

болохуйц хувь хүний үйлдэл. Энэхүү үйлдэл буруутай үйлдэл болоод эс үйлдэл эсхүл эдгээрийн нийлбэр байж болно. Дээрх ухагдахуун нь гэмт үйлдэл /**actus reus**/, гэмт сэдэлт /**mens rea**/ хэмээх гэмт хэргийн зайлшгүй бүрэлдэхүүний нэг хэсэг мөн.

Ихэнх гэмт хэргийн хувьд гэмт буруутай гэгдэх этгээд нь гэт хэрэг үйлдэх үед тодорхой гэмт санаа /оюун санааны байдал, өөрөөр хэлбэл мэдэж байсан эсхүл хүсэж зорьсон/-тайгаар гэмт үйлдэл /гэмт үйлдэл буюу эс үйлдэл-өмч булаан авах гэх мэт/-ийг хийсэн байх ёстой.

**Ad Hoc (Working Group/ Tribunal/Judge) [Latin, lit: to this thing]**

**Ad Hoc (Ажлын хэсэг/Тусгай шүүх/Шүүгч) [Латин: зөвхөн энэ зүйлд]**

Ерөнхийдөө зөвхөн тодорхой зорилгын хүрээнд, хязгаарлагдмал хугацаанд хамаарна гэсэн утгыг илэрхийлнэ.

1/ Ad Hoc ажлын хэсэг нь: Байгууллагын хүрээнд тодорхой нэгэн хязгаарлагдмал хүрээний

суудлыг шийдвэрлэх зорилгоор байгуулсан туслах хэсэг.

2/ Ad Hoc шүүх нь: Цэргийн гэмт хэрэг зэрэг тогтсон /тодорхой/, хязгаарлагдмал хэргийг шүүн таслах зорилгоор байгуулагдсан шүүх. 1945 оны Нюрнбергийн олон улсын цэргийн шүүх нь Дэлхийн II дайнд нацист Германы үйлдсэн олон улсын цэргийн гэмт хэргийг таслан шийдвэрлэх **ad hoc** шүүх байв.

3/ Ad Hoc шүүгч: Тодорхой хэргийг ганцар буюу шүүгчдийн бүрэлдэхүүнд багтаж шүүн шийдэхээр тусгайлан томилогдсон шүүгч.

**A Fortiori**

**A Fortiori**

Баттай нотлох баримт, логикийн улмаас зарим санал, үндэслэл нь үнэн байх магадлал өндөртэйг тодорхойлдог латин үг. Мөн “илүү хүчтэй үндэслэлийн улмаас” гэсэн утга агуулдаг. Жишээлбэл: Хэрэв ердийн тэсрэх бөмбөг иргэдийг олноор хөнөөдөг бол, тэр газар цөмийн бөмбөг хаявал илүү үй олон хүний амийг хөнөөх нь гарцаагүй юм.

**Amicus Curiae (Brief / Memorial) [Latin, lit: friend of court]**

**Amicus Curiae (Товчлол/ Айлтгал) [Латин: шүүхийн нөхөр]**

Шүүн таслах үйл ажиллагааны тал болж оролцох эрхгүй боловч шүүхийн зөвшөөрөлтэйгээр ховор тохиолддог төвөгтэй болоод эрх зүйн шинэхэн асуудлыг шийдвэрлэхэд шүүхэд дэмжлэг үзүүлж, өгөгдсөн асуудлаар баримт үндэслэл гаргах эрхтэйгээр оролцдог хувь хүн болон бүлэг этгээдийг хэлнэ.

Шүүхэд дуудагдсан **amicus curiae** болох хүн эсвэл байгууллага нь өөрийн байр сууриа илэрхийлсэн хэргийн товчоог бичгээр бүрдүүлж өгсөн байна. **Amicus curiae** нь олон улсын хэргийг шүүн таслах, давж заалдах шатанд оролцох хүсэлтээ тавих эрхтэй бөгөөд зөвхөн шүүхээс урьдчилан зөвшөөрсөн тохиолдолд уг шүүх хуралд оролцож болно. Олон тоон дээр **amici curiae** гэдэг.

**Bona Fide(s) (Principle) [Latin, lit: good faith]**

**Bona Fide(s) (Зарчим) [Латин: сайн итгэлцэл]**

Хувь хүн, төр, бүлэг хүн хүссэн зорилгодоо ёс суртахуун, ёс зүйн хувьд зөв гэж итгэсэн арга замаар хүрэх оюун санааны байдлыг энэхүү нэр үгээр илэрхийлдэг.

Энэ үг нь харилцааны хувьд шударга, нээлттэй /илэн далангүй/ эрх тэгш байдлыг илтгэнэ. Энэ нь олон улсын эрх зүй, олон улсын харилцааны зарчим бөгөөд улс орнууд олон улсын хамтын нийгэмлэг болон хамтран ажиллаж байгаа улс орны зүгээс хүлээгдэж байгаа зохистой үйлдэл хийхийг хэлнэ.

өөрөөр хэлбэл энх тайван, тогтвортой байдлыг дэмжих, олон улсын хамтын ажиллагаанд харилцан шүтэлцээг бэхжүүлэх зорилготойгоор эрх тэгш, нээлттэй үйл ажиллагаа явуулах гэсэн үг. Тэмдэг нэрээр уг үгийг хэрэглэвэл “ямар нэгэн хууран мэхлэх, залилах санаагүйгээр шударгаар хийсэн

эсхүл жинхэнэ ёсоор л байх ёстой” гэсэн санааг илэрхийлдэг.

**Casus Belli [Latin, lit: an occurrence of war]**

**Casus Belli [Латин: дайн дэгдэх]**

Нэг улс нөгөө улсыг басан доромжилсон үйлдэл нь нөгөө улсыг дайн зарлахад хүргэхийг хэлнэ. Ийнхүү басан доромжилсон нь дайн зарлахыг зөвтгөхүйц хэмжээнд хүрсэн байдаг.

**Cautio Judicatum Solvi (Bail Bond) [Latin, lit: court-determined bail bond for release]**

**Cautio Judicatum Solvi (Мөнгөн барьцаа) [Латин: цагдан хорихоос суллахад шүүхээс тогтоох барьцаа]**

Цагдан хоригдсон этгээдийг суллуулах зорилгоор таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа байгууллагын дансанд шилжүүлсэн бэлэн мөнгө буюу бусад үнэ бүхий зүйлийг хэлнэ. Суллагдсан этгээд байцаан шийтгэх болон шүүн таслах ажиллагаанд оролцох баталгаа болдог бөгөөд энэ шаардлагыг

эс биелүүлбээс барьцааны хөрөнгө улсын орлого болно.

**De Facto (эсрэг утга нь: De Jure)**

Латинаар “үнэн хэрэгтээ” гэсэн утгатай үг. Ямар нэг аливаа зүйл хуулиас хамааралгүйгээр амьдралд тохиолдох. Жишээлбэл : De Facto арьсны өнгөөр ялгаварлах гэдэг нь хуульд арьсны өнгөөр ялгаварлахыг заагаагүй боловч хүмүүс санаатай буюу санамсаргүйгээр арьсны өнгөөр ялгаварлах явдал тохиолддог гэсэн үг.

De Jure арьсны өнгөөр ялгаварлана гэдэг нь хуулийн дагуу өөр өнгөт арьстан хүмүүсийг нийтийн тээврээр зорчихыг хориглох зэргээр ялгаварлан гадуурхахыг хэлдэг.

De Facto хуульд заагаагүй хэдий ч амьдралд тохиолдож болох зүйл.

**De Jure (эсрэг утга нь: De Facto)**

Хууль заасны дагуу. Ямар нэг зүйл өөрөө тохиолдлоор бус хуульд заасны дагуу хэрэгжиж



байгааг хэлнэ. De Facto нь “үнэн хэрэгтээ” гэсэн утгатай бол De Jure нь хуульд заасны дагуу гэсэн санааг илтгэнэ.

**Desiderata [Latin, lit: things desired]**

**Desiderata [Латин: хүссэн зүйл]**

Даян дэлхийн энх тайван байдал, эрүүл, аюулгүй орчин, олон улсын нөхөрсөг харилцаа зэрэг хүний хүсэж мөрөөдөх бүхий л зүйлс гэсэн утгатай латин үг.

Гол төлөв эрх зүйн хэм хэмжээ болж амжаагүй зүйлсийг хэн нэгэн хуульчлахаар хүсэхийг илтгэдэг.

**Erga Omnes (Obligation) [Latin, lit: toward everyone/all]**

**Erga Omnes (үүрэг) [Латин: хүний бүхний/бүгдийн өмнө]**

Нийт улс гүрнүүдийн өмнө дагаж мөрдөх ёстой туйлын эрх, үүрэг бөгөөд түүнийг зөрчвөөс бүх улс уг зөрчлийг анхааралдаа авах хууль ёсны эрхтэй гэсэн үг. Геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг зэрэг нь нийгэм / давхарга/-ийг бүхэлд нь хохирол учруулах байдалд хүргэдэг тул

энэхүү үйлдлийн эсрэг үйл ажиллагаа явуулах эрх, үүрэг нь бүх нийтэд нээлттэй байдаг юм.

**Ex officio [Latin, lit: from official duty]**

**Ex officio [Латин: албан үүргээс]**

Энэ нь албан үүргийн хүрээнд ямарваа нэг үйл үйлдэх эсхүл ямар нэгэн албан тушаал хашдаг тул түндээ тохирсон тогтсон алба, байр суурь эзлэх, гишүүнчлэлд харьяалагдана гэсэн утгатай үг. Жишээлбэл: Европын улсуудын тэргүүнүүд нь **Ex officio** буюу албан тушаалын дагуу Европын Зөвлөлийн Сайд нарын хорооны гишүүд байдаг. АНУ-д Ерөнхийлөгч нь **Ex officio**-н хувьд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

**Grosso Modo (Interpretation) [Latin, lit: in a large manner]**

**Grosso Modo (Тайлбар) [Латин: өргөн утгаар]**

Ойролцоогоор, өргөн утгаар тайлбарлах, хэрэглэх, тодорхойлох гэсэн утгатай латин дайвар үг. Нарийвчлан тодорхойлох гэсэн үгний эсрэг утгатай.

**Habeas Corpus (Procedure)  
Habeas Corpus (Журам)**

Төрийн шоронд хоригдож байгаа этгээдийг баривчилсан болон хорьж байгаа шалтгаан нь хууль ёсны эсэхийг тогтоох, хууль бус бол суллах зорилгоор уг этгээдийг шүүхийн өмнө авчрахаар гаргасан өргөдлөөр үүсэх эрх зүйн процесс. **Amparo** гэсэн үг нь адил утгатай хэрэглэгддэг.

**In Toto**

Бүхэлд нь, цөмийг нь, бүх хэсгийг гэсэн утгатай латин дайвар үг. Хэсгээр, хэсэг хэсгээр, зарим хэсэгт гэсэн нь эсрэг утга. Жишээлбэл: “Х” улс Женевийн 4 конвенцийг **in toto** буюу бүгдийг нь хүлээн зөвшөөрсөн гэх мэт.

**Ipsa Facto [эсрэг утга нь: Ipsa Jure]**

Тухайн бодмт байдлаас үүдсэн, түүнд үндэслэсэн гэсэн утгатай латин үг. үйлдэл буюу бодит байдлын гарцаагүй үр дагавар. Жишээлбэл: 5 настай хүн гэдэг нь хүүхэд гэсэн утгыг илэрхийлж байна.

**Ipsa Jure [эсрэг утга нь: Ipsa Facto]**

Зөвхөн эрх зүйн дагуу гэсэн утгатай. Жишээлбэл: Дүрвэгсдийн тухай конвенцид дүрвэгсэд **Ipsa Jure** буцааж нүлгэн шилжүүлэхгүй байх зарчмын хамгаалалттай байх эрхтэйг заасан байдаг.

Х.Виктор Кондэ “Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага” номоос...

**Таны Хүний эрхийн мэдлэг шалгах сорил**

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэзээ батлагдсан бэ?
  - A. 1976 оны 4 сарын 5
  - B. 1923 оны 6 сарын 6
  - C. 1948 оны 12 сарын 10
  
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хаана баталсан бэ?
  - A. Дани Улсын Копенгаген хотын Рояль Палас
  - B. Франц Улсын Парис хотын Палай де Чайллот
  - C. Нью Йорк хотын НҮБ-ын Төв байр
  
3. Хэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын төслийг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн бэ?
  - A. Элеонар Рузвельт (АНУ)
  - B. Винстон Черчилль (Нэгдсэн вант улс)
  - C. Чарль де Гаулле (Франц Улс)
  
4. Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэдэн зүйлтэй вэ?
  - A. 120
  - B. 14
  - C. 30
  
5. Хүний эрхийн өдрийг хэзээ тэмдэглэдэг вэ?
  - A. 12 сарын 10
  - B. 9 сарын 23
  - C. 8 сарын 15
  
6. Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар хэдэн онд байгуулагдсан бэ?
  - A. 1954
  - B. 1973
  - C. 1993

7. НҮБ-ын ямар байгууллага Хүний Эрхийн Зөвлөлийг байгуулсан бэ?
- A. НҮБ-ын Аюулгүй Зөвлөл
  - B. Хүний Эрхийн Комисс
  - C. НҮБ-ын Ерөнхий Ассемблей
8. Хүний Эрхийн Зөвлөл хэдэн гишүүн оронтой вэ?
- A. 53
  - B. 191
  - C. 47
9. Хүний Эрхийн Зөвлөлийн гишүүнийг хэн сонгодог вэ?
- A. Аюулгүйн Зөвлөл
  - B. Эдийн засаг, нийгмийн зөвлөл
  - C. Ерөнхий Ассемблей
10. Хэн одоогийн Хүний эрхийн дээд комиссар вэ?
- A. Мери Робинсон
  - B. Кофи Аннан
  - C. Луиза Арбор
11. Террорист халдлагад өртөж, амь үрэгдсэн Хүний эрхийн дээд Комиссарыг нэрлэнэ үү.
- A. Даг Хаммарскжойд
  - B. Сержио Вьера де Мелло
  - C. Ральф Банч
12. Аль нь НҮБ-аас хамгийн анх баталсан баримт бичиг вэ?
- A. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
  - B. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дүрэм
  - C. Эмэгтэйчүүдийн эрхийн тухай тунхаглал
13. 2001 оны НҮБ-ын Арьс үндсээр ялгаварлан гадуурхахын эсрэг дэлхийн чуулган аль хотод болсон бэ?
- A. өмнөд Африк Улсын Дурбан хот
  - B. Хятад Улсын Бээжин хот
  - C. Бразил Улсын Сан Пауло

14. Хүний эрхийн асуудал дагнан хариуцсан НҮБ-ын байгууллагыг нэрлэнэ үү.
- A. Хүний Эрхийн Комисс
  - B. Аюулгүйн Зөвлөл
  - C. Хүний Эрхийн Зөвлөл
15. Дараах НҮБ-ын аль байгууллага хүний эрхийн зөрчилтэй холбоотой хувь хүний гомдлыг хүлээн авдаггүй вэ?
- A. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
  - B. Арьс үндсээр ялгаварлан гадуурхахын эсрэг хороо
  - C. Хүний Эрхийн Зөвлөл
16. Дараах баримт бичгийн аль нь гэрээнд үндэслэгдсэн байгууллагаар хянагдах олон улсын хүний эрхийн гэрээ биш вэ?
- A. Хүний эрхийн тунхаглал
  - B. Хүүхдийн эрхийн тухай конвенц
  - C. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц
17. Тусгай илтгэгч гэж хэн бэ? Юу хийдэг вэ?
- A. Тусгай илтгэгч гэдэгт НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын томилсон, өөрийн улсад хүний эрхийг хөхиүлэн дэмжих зорилготой алдар цуутай хүмүүсийг ойлгоно.
  - B. Тусгай илтгэгч гэдэгт Хүний Эрхийн Зөвлөлөөс томилогдож, цалин хөлсгүй ажилладаг шинжээчдийг хэлнэ. Хүний эрхийн нөхцөл байдлын шалгаж, хянан шинжилж, нийтэд илтгэх бөгөөд олон улсын хүний эрхийн баримт бичгийг тухайн Улс зөрчиж байгаа талаар шаардлага хүргүүлдэг.
  - C. Тусгай илтгэгч гэдэгт сайн дурын үндсэн дээр дэлхийгээр аялж, хүний эрхийн зөрчлийг хянан шинжилж, илтгэдэг хуулийн сургуулийн оюутнуудыг хэлнэ.
18. Хэнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал үйлчилдэг вэ?
- A. Арьс, үндэс, хүйс, шашин шүтлэг, угсаа гарвалыг харгалзахгүйгээр бүх хувь хүнд
  - B. 18 насанд хүрсэн бүх хүнд
  - C. Европын Холбооны бүх иргэдэд

19. Яагаад чамд Хүний эрхийн түгээмэл тунхаглал чухал хэрэгтэй вэ?
- A. Яагаад гэвэл Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь бүх гэрээнд үндэслэсэн байгууллагын үйл ажиллагааг урамшуулагч.
  - B. Яагаад гэвэл бусад хүмүүсийг хүндэлж сургадаг.
  - C. Яагаад гэвэл дур зоргоор баривчлахаас явдлаас хамгаалах баталгаа.
20. Хэдэн хүүхэд жил бүр хүчээр бие үнэлж байна вэ?
- A. Нэг сая хүүхэд (1,000,000)
  - B. Тавин сая хүүхэд (50,000,000)
  - C. Таван зуун мянган хүүхэд (500,000)
21. Дэлхийн хүн амын хэдэн хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлдэг вэ?
- A. 10
  - B. 28
  - C. 8
22. Дэлхий дээр 5-14 насны хэдэн хүүхэд хөдөлмөр эрхэлж байна вэ?
- A. 250 сая
  - B. 2 сая
  - C. 560 сая
23. Хэдэн хүүхэд тэжээлийн дутагдалд өртөж, хангалттай хоол хүнсээр хангагдаж чадахгүй байна вэ?
- A. 160 сая
  - B. Хагас тэрбум
  - C. 19 сая
24. Хэдэн хүн өдөрт 1,000 төгрөгөөс доош орлоготой байна вэ?
- A. 1.3 тэрбум
  - B. 700 сая
  - C. 2.7 тэрбум

25. Дэлхий дээрх ядуу хүмүүсийн хэдэн хувийг эмэгтэйчүүд эзэлж байна вэ?
- A. 22
  - B. 70
  - C. 54
26. Хэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны дараа Хүний эрхийн комиссын дарга болсон бэ?
- A. Винстон Черчилль
  - B. Элеонар Рузвельт
  - C. Двайт Д.Эйзенхаур
27. 1893 онд ямар улс анх эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийн бүрэн хүлээн зөвшөөрсөн бэ?
- A. Финланд Улс
  - B. Шинэ Зеланд Улс
  - C. Исланд Улс
28. 1969 онд Нью Йорк хотод болсон Стоунваллын үймээн нь \_\_\_\_\_-ийн хөдөлгөөнийг дэмжигч шинэчлэгчдийн үйлдэл байв.
- A. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх
  - B. Иргэний эрх
  - C. Лесби, гей, бисекс, трансжендер, жендерийн эрх
29. Ямар баримт бичигт анх хүний эрхийн зарчмуудыг бий болгосон бэ?
- A. Персийн эзэнт гүрний Аугаа хаан Цирусын зарлигаар бичсэн хуймал бичигт
  - B. Хүчирхийллийг үгүйсгэж, хүн бүр эрх тэгш, эрх чөлөөтэй болохыг тогтоосон Эртний Энэтхэгийн Ашока хааны зарлигт
  - C. Францын хувьсгалын үед батласан иргэний ба хүний эрхийн тунхаглалд
30. Хэдэн онд Хүүхдийн эрхийн тухай конвенци батлагдсан вэ?
- A. 1989
  - B. 1948
  - C. 1993

31. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хэдэн хэл дээр орчуулсан бэ?
- A. 30-150
  - B. 150-300
  - C. 300 болон түүнээс дээш
32. Ямар байгууллага хүний эрхийн стандартуудыг баталдаг вэ?
- A. Тухайн улсын Засгийн газар
  - B. Нэгдсэн Үндэстний Байгууллага
  - C. "Human Rights Watch" олон улсын байгууллага
33. Яагаад НҮБ-ын Хүний Эрхийн Комиссыг татан буулгасан бэ?
- A. Бүрэн эрхийн хугацаа дууссан тул
  - B. Үр нөлөөгүй гэж тооцсон тул
  - C. Маш их зардалтай байсан тул
34. Хүний Эрхийн Зөвлөлийн "Тусгай журам" гэж юу вэ?
- A. НҮБ-д хүний эрхийн зөрчлийн талаар хувь хүн гомдол гаргах боломж
  - B. Хүний эрхийг зөрчсөн бол Хүний Эрхийн Зөвлөл тухайн улсын үндэсний бодлогод хөндлөнгөөс оролцох журам
  - C. Үндэсний түвшинд гарсан хүний эрхийн зөрчлийг мөрдөн байцааж, Зөвлөлд илтгэх шинжээч болон ажлын хэсэг
35. Хэдэн оныг НҮБ-аас Хүний эрхийн олон улсын жилээр зарласан бэ?
- A. 1948
  - B. 1968
  - C. 1998
36. Хүний эрхийн олон улсын билл гэж юу вэ?
- A. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
  - B. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Хүүхдийн эрхийн тухай конвенц
  - C. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт



37. Хэдэн онд Хүний Эрхийн Зөвлөлийг байгуулсан бэ?
- A. 2006
  - B. 1981
  - C. 1948
38. НҮБ-ын ямар тунхаглалд эдийн засгийн үйл ажиллагааны зорилго нь хувь хүмүүсийн өсөлт, орлогыг бус, харин нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын сайн сайхан байдлыг сайжруулахад оршино хэмээн заасан бэ?
- A. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)
  - B. Хөгжих эрхийн тухай тунхаглал (1986)
  - C. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966)
39. Хэн анхны Хүний эрхийн дээд комиссар байсан бэ
- A. Элеонар Рузвельт
  - B. Даг Хаммарскжойд
  - C. Хосе Аяала Лассо
40. Дараах цуврал конвенцийн аль нь дайны үед баримтлах хүмүүнлэгийн үзэл баримтлалыг агуулсан байдаг вэ?
- A. Венийн конвенциуд
  - B. Женевийн конвенциуд
  - C. Ослогийн конвенциуд
41. Хэдэн хүний эрхийн гэрээнд үндэслэгдсэн байгууллага байдаг вэ?
- A. Хоёр
  - B. Гурав
  - C. Зургаа
42. Аль нь хамгийн олон улс соёрхон баталсан НҮБ-ын олон улсын гэрээ вэ?
- A. Хүүхдийн эрхийн тухай конвенц
  - B. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
  - C. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц

*Та өөрийн хүний эрхийн  
талаарх мэдлэгээ сорилын  
дагуу шалгаж зөв хариултыг  
2009 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө  
Хүний Эрхийн Үндэсний Комисст  
ирүүлнэ үү.*

*Сорилд зөв хариулсан  
эхний 5 уншигч Таны хаягаар  
“Хүний Эрх” сэтгүүлийн  
2009 оны дугааруудыг хүргэнэ*

### Манай хаяг

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН  
ҮНДЭСНИЙ КОМИСС

Улаанбаатар хот Эрх чөлөөний талбай  
Засгийн газрын 11 дүгээр байр 5 дугаар давхар  
“Хүний Эрх” сэтгүүлийн редакци  
Утас: 262789, 262902, 262931  
Факс: 262786  
Цахим шуудан: [info@mn-nhrc.org](mailto:info@mn-nhrc.org)

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИ**  
(Хүүхдэд зориулсан хялбаршуулсан хувилбар)

**Зүйл 1. Хүүхдийн тодорхойлолт**

Чамайг арван найман нас хүртэл хүүхэд хэмээн үзэж, энэ конвенцид заасан бүх эрхийг эдлүүлнэ.



**Зүйл 2. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх чөлөө**

Чамайг арьсны өнгө, хүйс, хэл, шүтдэг шашин, үзэл бодол, гарал үүсэл, нийгмийн болон эдийн засгийн байдал, хөгжлийн бэрхшээл, угсаа болон чиний, эсвэл чиний аав ээжийн, эсвэл асран хамгаалагчийн бусад байдлаар ялгаварлан гадуурхаж болохгүй.

**Зүйл 3. Хүүхдийн дээд ашиг сонирхол**

Хүүхдэд хамаатай бүх үйлдэл, шийдвэр нь чамд, эсвэл бусад хүүхдэд хамгийн сайн зүйлд тулгуурласан байх ёстой.

**Зүйл 4. Конвенцид заасан эрхүүдийг эдлэх**

Засгийн газар чамайг болон бүх хүүхдийн эрх эдлэх боломжийг бүрдүүлнэ.

**Зүйл 5. Эцэг эхийн удирдлага ба хүүхдийн өсөн хөгжиж буй ур чадвар**

Чиний гэр бүл чамайг өсгөх, байнга эрхээ ашиглаж сурахад удирдан чиглүүлэх үндсэн үүрэгтэй. Засгийн газар энэхүү эрхийг хүндэтгэнэ.



**Зүйл 6. Эсэн мэнд, хөгжих эрх**

Чи амьдарч, өсөн өндийх эрхтэй. Засгийн газар эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих нөхцлийг баталгаажуулна.



**Зүйл 7. Төрсний бүртгэл, нэр, улсын харьяалал, эцэг эхийн халамж**

Чи албан ёсоор төрснөө бүртгүүлэх, өөрийн нэртэй, улсын харьяалалтай байх, эцэг эхээ мэдэх, эцэг эхээрээ асрамжуулах эрхтэй.

**Зүйл 8. Хувь хүний тодорхойлолтыг хамгаалах**

Засгийн газар чиний өөрийн нэртэй байх, улсын харьяалалтай байх, гэр бүлийн халамжинд байх эрхийг хүндэтгэнэ.



**Зүйл 9. Эцэг эхээс салах**

Чиний сайн сайхны төлөө (жишээлбэл, эцэг эх чинь муухай харьцаж, үл ойшоодог) биш бол чамайг эцэг эхээс чинь салгаж болохгүй. Хэрэв чиний эцэг эх чинь салсан, чамд хүнд санагдахгүй бол чи хоёуланг нь холбоотой байх эрхтэй.

**Зүйл 10. Гэр бүл дахин нэгдэх**

Хэрэв чиний эцэг эх өөр улсад амьдардаг бол чамайг эцэг эхтэйгээ уулзах, гэр бүлтэйгээ нэгдэхээр улс хооронд явахыг зөвшөөрнө.



**Зүйл 11. Хууль бусаар өөр улс уруу шилжүүлэхээс хамгаалах**

Засгийн газар чамайг хууль бусаар өөрийн улсаас гарахаас сэргийлж, бүхий л арга хэмжээг авна.

**Зүйл 12. Хүүхдийн байр суурийг хүндэтгэх**

Чамд хамаатай шийдвэрийг насанд хүрсэн хүмүүс гаргах үед чи өөрийн юу бодож байгааг чөлөөтэй хэлэх, өөрийн байр суурьд анхаарлыг хандуулах эрхтэй.





**Зүйл 13. үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө**

Чамд болон бусад хүмүүст хохирол учруулахгүй бол чи бүх хэлбэрээр (бичиг, урлаг, телевиз, радио, Интернэт гэх мэт) мэдээллийг хайх, авах, хуваалцах эрхтэй.

**Зүйл 14. Бодол санаа, ухамсар, шашны эрх чөлөө**

Чи хүсэж байгаа зүйлээ бодох, итгэх, бусад хүмүүсийг эрхээ эдлэхэд саад болохгүйгээр өөрийн шашин шүтэх эрхтэй. Чиний эцэг эх чинь энэ асуудлаар чамайг удирдан чиглүүлнэ.



**Зүйл 15. Тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөө**

Бусад хүмүүсийг эрхээ эдлэхэд саад болохгүйгээр чи бусад хүүхдүүдийн бүлэг, байгууллагуудад орох, уулзах эрхтэй.

**Зүйл 16. Хувийн нууц, нэр төр, алдар хүнд**  
 Чи хувийн нууцтай байх эрхтэй. Хэн ч чиний нэр төрийг гутаах, танай гэрт нэвтрэх, захиа болон цахим шууданг унших, ямар нэгэн шалтгаангүй чамайг болон чиний гэр бүлд төвөг удах ёсгүй.



**Зүйл 17. Мэдээлэл, мэдээллийн хэрэгсэлд нэвтрэх**

Чи ном, сонин, сэтгүүл, телевиз, радио, Интернэт зэрэг төрөл бүрийн эх сурвалжаар холбогдох үнэн зөв мэдээлэл авах эрхтэй. Мэдээлэл нь чамд ашиг тустай, ойлгомжтой

байна.

**Зүйл 18. Эцэг эхийн хамтын үүрэг**

Чиний эцэг эх хоёулаа чамайг өсгөх, байнга чамд хамгийн тэргүүнд юу хэрэгтэйг харгалзан үзэх үүрэг



хүлээдэг. Засгийн газар, ялангуяа эцэг эх чинь ажил хийдэг бол эцэг эхэд чинь туслах үйлчилгээ үзүүлнэ.

**Зүйл 19. Хүчирхийлэх, зүй бусаар харьцах, үл ойшоох явдлын бүх хэлбэрээс хамгаалах**

Засгийн газар чамайг асрамжлан халамжилж, чиний эцэг эх болон чамайг харж байгаа бусад хүмүүс хүчирхийлэх, зүй бусаар харьцах, үл ойшоох явдлаас хамгаалахыг баталгаажуулна.



**Зүйл 20. Бусад халамж**

Хэрэв эцэг эх, гэр бүлийнхэн чамайг халамжилж чадахгүй бол чиний шашин, уламжлал, хэлийг хүндэтгэдэг бусад хүмүүсээр халамжлуулна.

**Зүйл 21. Өөрчлөлт**

Хэрэв чи өөрийн төрсөн оронд, эсвэл өөр улсад амьдрахаар үрчлэгдсэн бол эн тэргүүнд чамайг сайн сайхан байлгах бүх зүйлд анхаарлаа хандуулах ёстой.



**Зүйл 22. Дүрээгч хүүхэд**

Хэрэв чиний эх орон аюултай болсны улмаас өөр улсад ирсэн бол чи хамгаалуулах, дэмжлэг авах эрхтэй. Чи тус улсын хүүхдийн нэгэн адил эрх эдэлнэ.

**Зүйл 23. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд**

Хэрэв чи ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй бол өөрийн хамгийн сайн чадвараар бүрэн бүтэн, хараат бус амьдралыг бий болгох, нийгэмд идэвхтэй оролцохоор тусгай халамж, дэмжлэг авч, боловсрол эзэмшинэ.



**Зүйл 24. Эрүүл мэндийн үйлчилгээ**

Чи чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй (эм тариа, эмнэлэг, эрүүл мэндийн мэргэжилтэн гэх мэт). Чи эрүүл байхын тулд цэвэр ус, шим тэжээлт хоол, цэвэр орчин, эрүүл мэндийн боловсрол эзэмших эрхтэй. Баян улсууд ядуу улсуудад туслах ёстой.

**Зүйл 25. Эмчилгээний тогтмол хугацааны шалгалт**

Хэрэв чамайг эцэг эх биш, орон нутгийн байгууллага, ажилтан харж байгаа бол чамайг сайтар халамжилж, эмчилж байгааг тогтоохоор чиний нөхцөл байдлыг тодорхой хугацаанд шалгана.

**Зүйл 26. Нийгэм хамгааллын тэтгэмж**

Чиний амьдарч буй нийгэм чамайг хөгжих, сайн нөхцөл байдалд амьдрахад туслахаар нийгэм хамгааллын тэтгэмжийг олгоно (боловсрол, соёл, хүнс тэжээл, эрүүл мэнд, нийгмийн халамж). Засгийн газар шаардлагатай гэр бүлийн хүүхдэд нэмэлт мөнгө олгоно.

**Зүйл 27. Шаардлага хангах амьдралын түвшин**

Чи бие махбодийн, оюун санааны, итгэл үнэмшлийн, ёс суртахууны, нийгмийн хувьд хөгжих боломж бүхий эерэг нөхцөл байдалд амьдрах ёстой. Засгийн газар уг нөхцлийг бүрдүүлж чадаагүй гэр бүлд туслана.

**Зүйл 28. Сурч боловсрох эрх**

Чи сурч боловсрох эрхтэй. Сургуулийн багш нар чиний хүний нэр төрийг хүндэтгэх ёстой. Анхан шатны боловсролыг үнэ төлбөргүй,



заавал эзэмшинэ. Баян улсууд ядуу улсуудад туслах ёстой.

**Зүйл 29. Боловсролын зорилго**

Боловсрол нь чиний хувийн байдал, авьяас, оюун санааны болон бие махбодийн чадварыг бүрэн дүүрэн хөгжүүлнэ. Мөн чамайг амьдралд бэлтгэж, эцэг эх болон өөрийгөө, өөрийн улс, соёлыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлнэ. Чи өөрийн эрхийн талаар сурч мэдэх эрхтэй.



**Зүйл 30. Цөөнхийн хүүхдүүд, уугуул иргэд**

Чи өөрийн улсын ихэнх хүмүүстэй адил эсэхээс үл хамааран, өөрийн гэр бүлийн уламжлал, шашин, хэлийг сурах, хэрэглэх эрхтэй.

**Зүйл 31. Чөлөөт цаг, тоглоом, соёл**

Чи амрах, тоглох, хөгжилдөх, соёлын үйл ажиллагаанд оролцох эрхтэй.



**Зүйл 32. Хүүхдийн хөдөлмөр**

Засгийн газар чиний эрүүл мэндийг хохироосон, хөгжилд саад учруулсан, боловсрол олох нөхцлийг хаасан, бусад хүмүүс чамайг дарамтлан хүчээр ажиллуулахаас хамгаалах ёстой.

**Зүйл 33. Хүүхэд ба мансууруулах бодис**

Засгийн газар чамайг хортой, аюултай мансууруулах бодис хэрэглэх, хангах, тараахаас бүхий л байдлаар хамгаалах ёстой.



**Зүйл 34. Бэлгийн мөлжлөгөөс хамгаалах**

Засгийн газар чамайг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах ёстой.





**Зүйл 35. Хүний наймаа, хулгайгаас хамгаалах**

Засгийн газар чамайг хулгайлах, худалдах, өөр улсад аваачин, мөлжлөгт өртөхөөс хамгаалах ёстой.

**Зүйл 36. Бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалах**

Чи хөгжих, сайхан амьдрахад сөргөөр нөлөөлөх бүх үйл ажиллагаанаас хамгаалагдах ёстой.



**Зүйл 37. Эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах, эрх чөлөөг үл ойшоохоос хамгаалах**

Хэрэв чи хууль зөрчвөл чамтай хэрцгий харьцаж болохгүй. Чамайг насанд хүрсэн хүнтэй хамт шоронд хорьж болохгүй бөгөөд чи өөрийн гэр бүлийнхэнтэй холбоотой байх ёстой.

**Зүйл 38. Хүүхдийг зэвсэгтэн мөргөлдөн оролцуулахаас хамгаалах**

Хэрэв чи арван таван нас хүрээгүй бол (Европын ихэнх улсад арван найман нас хүрээгүй бол) засгийн газар чамайг дайны цагт цэрэгт татаж болохгүй. Дайны бүсэд байгаа хүүхэд тусгай хамгаалалтанд байна.



**Зүйл 39. Хохирогч хүүхдийг дахин сэргээх**

Хэрэв чамайг үл ойшоосон, эрүүдэн шүүсэн, эсвэл хүчирхийлсэн, мөлжлөгийн золиос болгосон, шоронд хорьсон бол чи бие махбодь болон оюун санаа, эрүүл мэндийг сэргээлгэх, дахин нийгэмд орохоор тусгай тусламж авах эрхтэй.



**Зүйл 40. Насанд хүрээгүй этгээдийг шүүх ажиллагаа**

Хэрэв чи хууль зөрчсөний улмаас гэмт хэрэгтэнд тооцогдсон ч чиний нэр төрийг хүндэтгэж үзнэ. Чи хууль зүйн туслалцаа авах, зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний төлөө шоронд хоригдох ёстой.

**Зүйл 41. Хүний эрхийн дээд стандартыг хүндэтгэх**

Хэрэв танай улсын хууль тогтоомжийн зохицуулалт энэ Конвенцийн зүйл заалтаас илүү хүүхдэд ашигтай бол хууль тогтоомжийг мөрдөнө.

**Зүйл 42. Конвенцийг олон нийтэд таниулах**

Засгийн газар Конвенцийг бүх эцэг эх, байгууллага, хүүхдүүдэд таниулах арга хэмжээ авна.

**Зүйл 43-54. Засгийн газрын үүрэг**

Энэ хэсэгт Засгийн газар болон насанд хүрсэн хүмүүс бүх хүүхэд өөрсдийн эрхийг мэддэг болохын төлөө хэрхэн хамтран ажиллахыг заасан болно.

## ҮГИЙН СҮЛЖЭЭ

### Хөндлөнгөөр:

1. Хүүхэд шашин шүтэх буюу ... ..үнэмшилтэй байх эрх чөлөөтэй.
10. Эрх эдлэгч ... ..– ны үндсэн дээр эрхээ шаардана.
13. Тусламж, туслалцаа
16. Бага насны хүүхдийг асран хамгаалуулахаар тогтоосон иргэн
21. Ямар нэгэн болзол, нөхцөлгүйгээр нэн тэргүүнд тавих ёстой хэмээн тооцогддог хүний эрх
22. Нэгдсэн Үндэстний ... ..
24. Юмыг хасах буюу хэмжээ тогтоож зогсоох үйл явц
26. Нийгмийн цөм болсон нэгж
31. Хүнийг арьс, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, гарал үүсэл, эд хөрөнгө, төрсөн газар ба бусад нийгмийн байдал дээр тулгуурласан ямарваа нэгэн зайлуулах, гадуурхах, хориглох эсвэл илүүд үзэх байдлаар хүн бүрт адил тэгш оноогдсон хүний эрх, эрх чөлөөг үгүйсгэх буюу устгах зорилго агуулсан үйлдэл
33. Хүмүүсийн харьцааны цогц
39. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 23 дугаар зүйлд чадамжийн ялгаатай хүүхдийг тодорхойлсон нэр
41. Нийгмийн харилцааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц
45. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 19 дүгээр зүйлд тодорхой болох, боловсрох үйл явцыг илэрхийлсэн нэр
46. Аливаа юманд хэрэглэгдэх зүйл
51. Хүн бүрийн үнэ цэнэ, эрхэм чанарыг хүндэтгэх үүднээс бий болсон ойлголт
52. Нийгэм журмын хэлбэртэй хүмүүсийн нэгдэл

**Босоогоор:**

2. Тоглох, наадахад хэрэглэх зүйл
3. Эцэг эх, төрөл ургаа зохистойгоор хүндэтгэн үйлчлэхийн нэр
4. Хүүхэд хөндлөнгийн оролцоо, халдлагаас хуулиар ... .. эрхтэй.
5. Хүний эрх нь жам ёсны бөгөөд хүнээс ... .. шинжтэй.
8. Хүний эрх бүх хүнд ялгаваргүйгээр, тэгш хүртэх ... .. шинжтэй.
9. Дадлага, туршлагын шинэ чиг баримжаа
11. Өөр өөр хэмжигдэхүүн, юм, үйл явдлыг жишсэн жишиг, харилцаа
12. Хөрөнгө, амьдрал ахуйгаар дутмаг үгээгүү, дорой болсон байдал
14. Үүрэг хүлээгч нар үүргээ биелүүлэхгүй бол ... .. тооцно.
15. Хүүхдийн аж байдал, үйлдсэн хэргийн байдалд тохируулан хандах үүднээс ... .. арга хэмжээ авна. (Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 40.4 дүгээр зүйл)
17. Хүүхдийн эрхийн тухай конвенцид оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд ... .. бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана.
18. Чармайлт, санаачлага, мэрийлт
19. Оролцогч улсууд хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр ... .., худалдах буюу хил дамжуулан худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна.
25. Хүүхдийн нялх үе
27. Хүний зарим эрхийг орхигдуулан цогц бус байдлаар хүндэтгэх явдлыг хангалтгүй гэж үздэг тул хүний эрх нь ... .. болно.
28. НҮБ-ын Нарийн бичгийн даргын газрыг тэргүүлэгч, НҮБ-ын дээд удирдах ажилтан
29. Тодорхой улстай тогтоосон тухайн хүний эрх зүйн тогтвортой холбоо бөгөөд тэдгээрийн харилцан хүлээх эрх, үүрэг
30. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх үе шат
32. Үндсэн хууль, бусад хуулиар бэхжүүлсэн хүний тодорхой зан үйлийн боломж

34. Хүүхдийг асран халамжлахад ... .., шашин болон соёлын хамаарал, төрөлх хэлийг зохих ёсоор харгалзан үзэх ёстой.

35. Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орж, соёрхон баталж, үүрэг хүлээсэн этгээдийн тодорхойлолт

36. Хүүхдийн эрхийн тухай ... .. 1989 онд батлагдсан билээ.

37. Хүүхэд өөрт хамаатай ... .. гаргах үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

38. 0 – 18 нас хүртэлх хүн

40. Хувь хүнд угаас заяагдсан, хүндэтгэж харьцах үнэт зүйл

42. Санал хураалтад талууд татгалзсан санал гаргахгүйгээр шийдвэрт хүрэх үйл явц

43. Аливаа этгээд бүхий л үйл ажиллагаанд хүүхдийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьж, учрах бэрхшээлд анхаарлаа ... .. ёстой.

44. Харилцан учрыг харилцан мэдэх үйл

47. Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, ... .., эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана.

48. Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага хүүхдийн ... .. –ыг хангана.

49. Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, ... .. –ын давуу тал, эрүүл ахуй, амьдрах орчны ариун цэвэр, осол аюулаас урьдчилан сэргийлэх талаархи мэдээллээр нийгмийн бүх давхарга, түүний дотор эцэг эх, хүүхдийг хангах, түүнчлэн энэ талын боловсролтой болох, суурь мэдлэгээ ашиглахад дэмжлэг тусалцаа үзүүлэх арга хэмжээг Оролцогч улс авна.

50. Хүн бүр чадвартаа түшиглэн ... .. эзэмших бололцоог шаардлагатай бүх арга замаар хангагдана.

**Ташуугаар:**

6. Үүрэг хүлээгч нар эрх эдлэгчийн ашиг сонирхол, ... .. – ийг харгалзана.

7. Эрх зүйт ёс нь ... ..-ы эрхийн онолтой шууд холбоотой.

20. Эрх нь зөрчигдсөн этгээд

23. Эрхэд суурилсан хандлагад тулгуурлан, хууль тогтоомжийг өөрчилснөөр хууль тогтоомжийн ... .. – нд эерэг үр дүн гарна.

